Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2020 оны 5 дугаар сар

# МОН 49430: Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр (АСХХОХ):

## Жаргалант, Ховд Аймаг

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны төлөв байдлын үнэлгээний нэг хэсэг юм. Энэ нь зээлдэгчийн баримт бичиг. Иймд АХБ-ны Захирлуудын зөвлөл, удирдлага, ажилтнуудын үзэл бодлыг төлөөлөхгүй бөгөөд бүрэн дүүрэн боловсруулагдаагүй байж болно

## ХАНШИЙН ХАРЬЦУУЛАЛТ
(2019 оны 9 дүгээр сарын 3)

| | | |
|---|---|---|
| Мөнгөний нэгж | – | Төгрөг (MNT) |
| Төгрөг 1.00 | = | $0.00038 |
| $1.00 | = | Төгрөг 2,620 |

## ТОВЧИЛСОН ҮГ

| | | |
|---|---|---|
| АХБ | - | Азийн Хөгжлийн банк |
| АСХХОХ | - | Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр |
| ГЗБГЗЗГ | - | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй |
| АМС | - | Хөрөнгийн үнэлгээний байгууллага |
| БОАХТХГ | - | Байгаль орчны арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэрээлэгч |
| БОГ | - | Аймгийн Байгаль орчны газар |
| МУХБ | - | Монгол улсын Хөгжлийн банк |
| БОНБҮ | - | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ |
| БОМТ | - | Байгаль орчны арга хэмжээний төлөвлөгөө |
| БОХМТ | - | Байгаль орчны хяналт монторингийн тайлан |
| МУЗГ | - | Монгол улсын засгийн газар |
| ГБА | - | Гомдол бараглуулах ажиллагаа |
| БОТБҮ | - | Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ |
| БОАЖЯ | - | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| Төг | - | Монгол төгрөг |
| БХБЯ | - | Барилга, хот байгуулалтын яам |
| ХААХҮЯ | - | Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| ҮБАШ | - | Үндэсний бэлчээр ашиглагчдын холбоо |
| ТОСК | - | Төрийн орон сууцны корпараци |
| ТХН | - | Төсөл хэрэгжүүлэгч нэгж |
| ТТГ | - | Төслийн туслан гүйцэтгэгч |
| БОТҮ | - | Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээ |
| НШТ | - | Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө |
| ХБББ | - | Хамгааллын бодлогын баримт бичиг (2009) |
| Ам. доллар | - | АНУ-ын доллар |

**Жин, хэмжүүр**

| | | |
|---|---|---|
| км | - | Километр |
| $км^2$ | | Километр квадрат |
| кг | - | Килограмм |
| га | - | Гектар |
| м | - | Метр |
| $м^3$ | - | Куб. метр |
| мг | - | Миллиграмм |
| мг/л | - | Миллиграмм литр |
| тн | - | Тонн. |

Энэ тайланд ам. долларын "$" гэж тэмдэглэв.

**Агуулга**

I. **ТАНИЛЦУУЛГА** 14

A. АСХХОХ-ийн ерөнхий тойм 14

II. **БАЙГУУЛЛАГЫН ЗОХИЦУУЛАЛТ БА ХҮЛЭЭХ ҮҮРЭГ** 15

A. Төслийн түвшинд 15

B. Ховд аймаг – Жаргалант сумын төв 16

III. **БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛҮҮДИЙН ТУХАЙ ТОВЧ ДҮГНЭЛТ** 19

IV. **ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ** 21

V. **НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ** 22

VI. **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ** 40

A. АСХХОХ-ийн 1-р ээлжид хамааралтай байгаль орчны чанарын стандартууд 40

B. Гүйцэтгэлийн хяналт 40

C. Тайлагнах 40

D. БОМТ-ний тооцоот зардал 45

E. Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө 45

**ХАВСРАЛТ А. МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧАНАРЫН СТАНДАРТУУД** 46

**ХАВСРАЛТ В. АЙМАГ, СУМ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГИЙН ЖИШЭЭ** 52

**ХАВСРАЛТ С: ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД АВАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ** 53

F. Дохиололын журам 54

G. Онцгой байдлын үед авах арга хэмжээ. 55

Хүснэгт 1. Жаргалант сумын төвд төлөвлөж буй хөрөнгө оруулалт

Хүснэгт 2. Ховд аймгийн БОМТ-г хэрэгжүүлэх чиглэлээр хүлээх үүрэг хариуцлагын тойм

Хүснэгт 3. АСХХОХ-ийн болзошгүй нөлөөллүүдийн хураангуй

Хүснэгт 4. Нөлөөллийг бууруулах төлөвлөгөө – Увс аймаг

Хүснэгт 5. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. АСХХОХ-ийн гүйцэтгэлийн хяналтын үзүүлэлтүүд

ХҮСНЭГТ 7. Ховд аймгийн БОМТ-ний жишиг зардал

Хүснэгт 8. Онцгой байдлын үед авах арга хэмжээ, хүлээх үүрэг хариуцлага

Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх журам

Хүснэгт 10. Эмнэлгийн яаралтай тусламжийн үед авах арга хэмжээний үед мөрдөх журам

Хүснэгт 11 Гал түймрийн үед авах арга хэмжээний үед мөрдөх журам

Зураг 1. АСХХОХ-ийн байгууллагуудын зохицуулалт

# I. ТАНИЛЦУУЛГА

1. (АСХХОХ) Аймаг, сум хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1-р үе шат нь баруун гурван аймаг болох Увс, Баян-Өлгий, Ховдыг хамарна. Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн Ховд аймгийн газар нутагт орших Ховд аймгийн төв болон Жаргалант сумын төвд зориулж боловсруулсан болно. Төсөлд хамрагдаж буй Увс, Ховд аймгуудад БОМТ-ийг тус тусад нь бэлтгэн гаргав.

2. БОМТ нь АСХХОХ -ийн 1-р үе шатанд Жаргалант суманд хөгжүүлэх дэд бүтэц, агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хэрэгжилтийг барилга угсралтын өмнөх, барилга угсралтын ажлын явцад болон түүний дараах үе шатуудаар дамжуулан удирдах бөгөөд байгаль орчины төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлогдсон байгаль орчин болон нийгэмд учрах шаардлагагүй нөлөөллүүдийг үүсгэхгүй байх мөн төслийн бүрэлдэхүүн хэсгүүдээс үүсэх нөлөөллийг хэмжиж, баримтжуулахад чиглэх болно.

3. Энэхүү БОМТ нь барилгын ажил гүйцэтгэгч компаниудад барилгын багцын тендерийн баримт бичгийн иж бүрдэлд багтах гүйцэтгэгчийн БОМТ-г (ГБОМТ) боловсруулахад нь чиглэл өгөх болно. Бусад хоёр аймгийн БОМТ-тэй адилаар Жаргалант суман дахь 1-р үе шатны ТЭЗҮ-ийн БОМТ-г цогц бие даасан менежментийн хэрэгсэл болгон боловсруулсан бөгөөд цаашдаа нарийвчилсан зураг төслийн үе шатанд шинэчлэгдэж байх болно.

## A. АСХХОХ-ийн ерөнхий тойм

4. Хөтөлбөр нь зорилтот бүс аймгуудад, хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй ногоон хот байгуулалт, бэлчээрийн тогтвортой менежмент, тогтвортой агробизнесийн нэмүү өртгийн сүлжээ, өрсөлдөх чадвартай нутаг дэвсгэрийн хөгжлийг дэмжинэ. Аймаг бүрт тус хөтөлбөр нь ногоон хот байгуулалт болон хөдөөгийн дэд бүтцийн уялдааг боловсронгуй болгохыг дэмжсэн агробизнес болон бэлчээрийн менежментэд бодит хөрөнгө оруулалт хийх, өнөөгийн арга хэмжээг бэхжүүлэхэд чиглэнэ. АСХХОХ-ийн хөрөнгө оруулалт нь монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд өртөх нөлөөлөл, эмзэг байдал болон бэлчээрийн доройтлыг бууруулахад чиглэгдэнэ.

5. Нийгмийн олон салбар чиглэлийг хамарсан АСХХОХ- нь бүс нутгийн болон хот суурины эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор төслийн 1- р үе шатандаа сонгогдсон гурван аймгийн төвүүд болон дөрвөн сумдын төвүүдэд дараах томоохон хоёр бүрэлдэхүүн хэсгүүдэд хөрөнгө оруулалт хийнэ:

(i) Хотын дэд бүтэц, нийтийн аж ахуйн үндсэн үйлчилгээ болон байгууламж,

(ii) Агро-үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон бэлчээрийн менежментийг сайжруулах

Гэвч Увс, Баян-Өлгий аймгуудаас ялгаатай нь АСХХОХ-ийн 1-р үе шатанд Ховд аймгийн төвийн сумын төвд хийгдэх хөрөнгө оруулалт хийгдэхгүй ба дараагийн үе шатанд хийгдэнэ.

6. Дараах хүснэгтэд 1-д Ховд аймгийн Жаргалант сумын төвд хийгдэхээр төлөвлөгдсөн 1-р үе шатны хөрөнгө оруулалтыг д нэгтгэж харуулав. Хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь үндсэндээ аймаг, сумын төвүүдэд хийгдэх бол агро-үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нь аймаг сумын төвд ойрхон орших газруудад чиглэгдэх болно. Агро-үйлдвэрлэлийн шинэ байгууламжуудад хийгдэх хөрөнгө оруулалтад дэд бүтцийн хөрөнгө

оруулалт мөн адил хийгдэнэ

### Хүснэгт 1. Жаргалант сумын төвд төлөвлөж буй хөрөнгө оруулалт

| **Хот болон Агропаркийн дэд бүтцэд хийгдэх хөрөнгө оруулалт** | |
|---|---|
| • Гэр хорооллын дахин төлөвлөлт[1] | • Дулаан хангамжийн шугам сүлжээг сайжруулах |
| • Зам засаж сайжруулах, ус зайлуулах дренаж, шугам хоолой | • Харилцаа холбооны цамхаг, шилэн кабелийн сүлжээ |
| • Бохир ус зайлуулах сүлжээг сайжруулах, (Б УЦБ ) бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих буюу өргөтгөх | • үерийн хамгаалалтын даланг сэргээн засварлах |
| • Ундны усыг ариутгах, ус түгээх сүлжээг сайжруулах | • Хог хаягдлын цэгийг сайжруулах |
| • Цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах | • Сургууль, эмнэлэг, захиргааны барилгыг өргөтгөх, шинэчлэн засварлах |
| **Агро-үйлдвэрлэлд хийгдэх хөрөнгө оруулалт *** | |
| Бэлчээр ашиглагчдын бүлгүүдэд[2] чиглэсэн олон нийтэд суурилсан төсөл:<br>- бичил мал аж ахуй<br>- хадлан тэжээлийн талбай, агуулах сав<br>- бага оврын усалгаа<br>- худаг усыг сайжруулах<br>- жижиг гол дээр гүүр барих<br>Тэжээлийн аж ахуй ба усалгааны системийн сүлжээ | • Агро парк<br><br>- хорио цээрийн бүс (ХЦБ)<br>- мах боловсруулах үйлдвэр<br>- мал эмнэлэг лабораторийн үйлчилгээ<br>- судалгааны төв<br>- бизнес инкубатор төвүүд<br>- боловсруулах үйлдвэрүүд |

* ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭД БҮТЦИЙН ХАМТ ХЭРЭГЖҮҮЛНЭ

### 1. Үнэлгээний агуулга

7. АСТХХОХ нь АХБ-ХБББ (2009) болон тэргүүн туршлагын эмхэтгэлд (2012) заасны дагуу байгаль орчны хувьд Б зэрэглэлд хамаарна. Хөрөнгө оруулалтын 1-р үе шатны хувьд БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газраас байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБҮ) хийхийг шаардах болно

## II. БАЙГУУЛЛАГЫН ЗОХИЦУУЛАЛТ БА ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

### A. Төслийн түвшинд

8. АСХХОХ-ийн зохицуулалтыг дор нэгтгэж, зураг 1-д тусгалаа. Сангийн Яамаар ахлуулж БХБЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ), зорилтот аймгуудын удирдлагууд оролцсон, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлого стратегийн чиглэл өгөх, яам, агентлагуудын уялдаа холбоог хангах зорилго бүхий Төслийн удирдах хороог (ТУХ) байгуулна. Төслийн хэрэгжилтийг шууд удирдах, хяналт тавих зорилгоор БХБЯ, ХХААХҮЯ, МУХБ, аймгуудын удирдлагыг оролцуулсан Гүйцэтгэх ажлын хэсэг (ГАХ) байгуулагдана. Төслийг гүйцэтгэх агентлаг (ГА) нь БХБЯ байх бөгөөд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж төслийн хэрэгжилтэд хяналт тавина. ГА нь ТУХ болон ГАХ-ын удирдлага дор ажиллана. БХБЯ-ны дэргэд Хөтөлбөрийн менежментийн алба (ХМА) байгуулагдах бөгөөд захирал нь ГЗБГЗЗГ-ын дарга байх болно. ХМА-ыг албаны захирал удирдах ба гурван дэд зохицуулагч бүхий гурван хэлтэстэй байна. Үүнд: (i) хот суурин, нутаг дэвсгэрийн хөгжилийн асуудал хариуцсан хэлтэс (БХБЯ-тай уялдаж хамтран ажиллана); (ii) бэлчээрийн менежмент, хөдөө аж ахуйн бүрэлдэхүүн хэсгийг хариуцсан хэлтэс (ХМА-ны дарга, зохицуулагчид тайлагнах, ХХААХҮЯ-тай уялдаж хамтран ажиллана); (iii) худалдан авалт, санхүү, хамгаалллын асуудал, магадлан шинжилгээний асуудлыг хариуцсан хэлтэс (ХМА-ны захирал болон зохицуулагчид шууд тайлагнана); Төслийн СЗЗ

[1] *sensu*, Ulaanbaatar Affordable Green Housing and Resilient Urban Renewal Project (AHURP), TA 9030, 2017.
[2] Pasture User Groups

хэсгийг удирдах Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийг (ХХН) МУХБ-ны шууд удирдлага дор МУХБ-ХУК-ын зүгээс байгуулах ба энэ нэгж нь ХУН-ийн захирал, зохицуулагчтай хамтран уялдаж ажиллана.

### 1. Аймгийн Хэмжээнд

A
U
T
O
N
U
M

Аймгийн төслийн нэгж (АТН), төслийн зорилтот сумдад сумын хэрэгжүүлэх алба (СХА) байгуулагдана. Алба тус бүр хот байгуулалт, бэлчээрийн менежмент, агро-бизнес, хамгаалал, магадлан шинжилгээний багтай байна. АТА тус бүрт зохицуулагч байх бөгөөд ХУН-ийн захирал, зохицуулагчдад тайлагнах бөгөөд Аймгийн [illegible] арьс шир, нэхий бүтээгдэхүүн үйлдвэрлэгдийн холбооны төлөөлөл, МҮХАҮТ, малчдын байгууллага, хоршоодоос бүрдсэн [illegible] удирдамж болгон боловсруулсан БОНУС-аас тусад нь боловсруулна

### 2. Бие даасан СЗЗ-ийн хэсгийн байгаль орчны менежмент

10. [illegible]

### B. Ховд аймаг – Жаргалант сумын төв

11. Ховд аймагт 1-р үе шатны БОМТ-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий анхан шатны менежментийн бүтцийг дараах байдлаар харуулав. Төслийн гүйцэтгэх агентлаг (ГА) нь БХБЯ байх БОМТ-ийг аймгийн төв Жаргалант сумын төвд хэрэгжүүлэх ажлыг нийтэд нь хариуцах ба шаардлагатай тохиолдолд ГАХ эсвэл ТУХ-оос өндөр түвшний шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ. УБ-т байрлах ХМА-ны худалдан авалт, санхүү, хамгаалал, магадлан шинжилгээний асуудал хариуцсан хэлтсийн Зохицуулагчаас #3 (Зураг 1) нийгмийн хамгааллын ажилтантай хамтран ажиллах байгаль орчны хамгааллын ажилтныг (БОХА) томилно. БОХА нь Ховд аймагт БОМТ-г амжилттай хэрэгжүүлэх асуудлыг хариуцна. БОХА нь Ховд дэх АТА-ны зохицуулагчтай нягт хамтран ажиллана. Аймгийн зохицуулагч нь АТА-ны хамгаалал, магадлан шинжилгээний баг ажиллах аймгийн байгаль орчны хамгааллын ажилтныг (АБОХА) томилно. АБОХА нь Жаргалант сумын БОМТ-г зохих түвшинд хэрэгжүүлэхийн тулд төслийн талбай дээр ажиллах ба БОХА-ны дэмжлэг авна. АБОХА нь эргээд Жаргалант сум дахь БОМТ-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сумын төслийн хэрэгжилтийн нэгжтэй (СДТХН) нягт хамтран ажиллаж, удирдан чиглүүлэх болно. АБОХА нь БОХА-ийн дэмжлэгтэйгээр барилгын ажлын гэрээт гүйцэтгэгчдийн зүгээс хийж буй ГБОМТ-ний гүйцэтгэлийг удирдаж хянана. Гүйцэтгэгч нь Ховд аймгийн төслийн барилгын ажлын тендерийн баримт бичигт тусгагдсан БОМТ-нд үндэслэж ГБОМТ-г боловсруулах ба тендерийн санал баримт бичигтээ тусгасан байна.

Зураг 1. АСХХОХ-ийн байгууллагуудын зохицуулалт




12.  БОХА ба ТХХТЗ-ийн (доорхи) дэмжлэгтэйгээр АБОХА нь Жаргалант сумын БОМТ-г амжилттай хийж гүйцэтгэхэд чиглэсэн өдөр тутмын ажлыг хариуцна. БОМТ-ний хяналт шинжилгээний төлөвлөгөөнд тусгагдсан Жаргалант суманд хийгдэх байгаль орчны хяналт шинжилгээ, дүгнэлтийг БОНҮ хийх эрх бүхий Монгол улсын ААН гүйцэтгэнэ

13.  Төслийг хэрэгжүүлэх ба хяналт тавих зөвлөх багийн (ТХХТЗБ) байгаль орчны олон улсын мэргэжилтэн (БООУМ) байгаль хамгааллын ажилтнуудад БОМТ-г хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана. ТХХТЗБ нь АСХХОХ-ийн 1-р үе шатны нарийвчилсан зураг төсөл болон хэрэгжилтэд хяналт тавихаар АХБ-ны байгаль орчны хамгааллын ажилтны хамт ажиллах болно. Барилгын багц ажлын гэрээт гүйцэтгэгчид нь Ховд аймгийн төслийн тендерийн баримт бичигт тусгагдсан БОМТ-нд үндэслэж боловсруулсан өөрийн ГБОМТ-г хэрэгжүүлэх үүрэгтэй. 1-р үе шатны байгаль орчны менежментийн чиглэлээр ажиллах байгууллага, ажилтнуудын гол болон туслах үүрэг хариуцлагыг тодорхойлж, доорхи Хүснэгт 2- т нэгтгэн харуулав

A
U
T
O
N
U
M

15.  Төслийн удирдах хороо нь ГАХ-ийн дэмжлэгтэйгээр: (i) засгийн газрын түвшинд арга хэмжээ авах шаардлагатай байгаль орчны менежментийн аливаа асуудлаар шийдвэр гаргана (ii) БОМТ-ний хэрэгжилт түүний дотор байгаль орчны хяналтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг мөн тухайд нь хуваарилах ажлыг хангана. ТУХ/ГАХ нь БОХА болон АБОХА-аар дамжуулж байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэх, Жаргалант суман дахь төсөлд хамрагдаж буй нутгийн оршин суугчид, хувийн хэвшлийнхний зүгээс шаардлагатай дэмжлэг туслалцаа авах мөн түүнчлэн олон нийттэй зөвлөлдөх, тэдэнд мэдээлэл өгөх, байгаль орчны хяналт-шинжилгээ, болон гомдол шийдвэрлэх механизмыг (ГШМ) хэрэгжүүлэх чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

БХБЯ нь төслийн эзэмшигч бөгөөд гүйцэтгэгч агентлаг болохынхоо хувьд Ховд аймгийн БОМТ-г амжилттай хэрэгжүүлж дуусгах, шаардлагатай бол БОАЖЯ, АХБ-тай хамтран ажиллах үндсэн үүрэгтэй.

A
U
T
O
N
U
M



Ховд аймаг дахь Зохицуулагч нь АБОХА-ны дэмжлэгтэйгээр аймгийн БОМТ-ний өдөр тутмын үйл ажиллагааг явуулах, удирдах үүрэгтэй. ХХН-ийн АБОХА нь ТХХТЗБ-БООУМ-ний дэмжлэгтэйгээр дараах ажлуудаас бүрдэх БОМТ-ний хэрэгжилтийг зохион байгуулж, хянаж ажиллах ба хийх ажил зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд (a) нарийвчилсан зураг төсөл гарсны дараа БОМТ-г шинэчлэх; (b) БОМТ-ний зөвлөмжийг гүйцэтгэгчийн зураг төсөл/тендерийн баримт бичигт тусгасан байдлыг

батлуулах; (d) шаардлагатай бол Жаргалант сум дахь нөлөөлөлд өртөж буй газар нутгийн хүрээлэн буй орчны нэмэлт суурь мэдээллийг (орчны агаар, гүний болон гадаргын усны чанар, дуу чимээ, замын хөдөлгөөний асуудал) олж авах; (e) Гомдол барагдуулах механизмыг баталгаажуулж ба зохион байгуулж ажиллах; (f) сонгогдсон гүйцэтгэгчдийн ГБОМТ-г хянаж, тодруулах; (g) Гүйцэтгэгчдийг БОМТ-г дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах; (h) ТХХТЗ-тэй хамтран гүйцэтгэх орчны хяналт шинжилгээний жилийн тайлангуудын нэг хэсэг болох БОМТ-ний хэрэгжилтийн тайланг сар бүр гаргаж ГА-д хүргүүлэх; (i) шаардлагатай тохиолдолд орон нутгийн оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, яг гүйцэтгэгдэж буй барилгын ажын талаар болон төслийн хамгийн сүүлийн үеийн үйл ажиллагаа, ГБМ-ын талаар оролцогч талуудад шинэчилсэн мэдээлэл өгөх; (j) ТХХТЗ - БООУМ-ний (дooроос үзнэ үү) явуулж буй сургалтад дэмжлэг үзүүлж, БОМТ-г хэрхэн дагаж мөрдөж буй байдалд хяналт тавих, жилийн тайланг хянах.

17. Гүйцэтгэгч нь БОМТ-нд бүрэн нийцсэн өөрсдийн БОМТ-г (ГБОМТ) боловсруулж, хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь хяналт (дотооддоо) тавина. Үүнд: (а) тендерт оролцогчид нь ирүүлэх саналдаа төсөвт багтаах байгаль орчны арга хэмжээнүүдийн жагсаалтыг тусгана, (б) гэрээний нөхцлийн байгаль орчны талаархи заалтууд тусгагдсан байна.

Хүснэгт 2.. Ховд аймгийн БОМТ-г хэрэгжүүлэх чиглэлээр хүлээх үүрэг хариуцлагын тойм

| **Үе шат** | **Хариуцах байгууллагууд** | **Байгаль орчны чиглэлээр хариуцах үүрэг** |
|---|---|---|
| Төслийн бэлтгэл | БОАЖЯ | АСХХОХ-ийн БОНЕҮ хийх<br>АСХХОХ-ийн БОМТ эсвэл БОННҮ-г хянаж батлуулах |
| | ГА, Ховд Баян-Өлгийн Аймгийн төслийн нэгж | БОАЖЯ-д хандаж БОНЕҮ хийх хүсэлт гаргана. БОАЖЯ-ны журмын дагуу болон АХБ-ХБББ-т (2009) заасан БОҮХХ-ний дагуу БОТБҮ-г хийж гүйцэтгэнэ.<br>Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх тухай хуулийн (2012) дагуу БОННҮ эсвэл БОМТ-г боловсруулна. |
| | Төсөлд бэлтгэх ТТ-ны зөвлөхүүд | БОАЖЯ-нд хүсэлт гаргахад нь ХА-т туслалцаа үзүүлэх, БОТБҮ бэлтгэх (АХБ-ХБББ 2009) |
| | АХБ | БОТБҮ, БОНБТ-г хянаж зөвшөөрөх, АХБ-ны вэбсайт дээр мэдээлэх |
| Нарийвчилсан зураг төсөл | (Төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөх баг) | Нарийвчилсан зураг төсөл болон тендерийн баримт бичигт байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг тусгах |
| | Жаргалант сумын АТН, ТХХТЗБ-БООУМ | БОМТ-г Нарийвчилсан зураг төсөлтэй уялдуулж шинэчлэнэ. Шинэчилсэн БОМТ-г АХБ-д өгнө. |
| | АХБ | Approve updated EMP БОТБҮ, БОНБТ-г хянаж зөвшөөрөх, АХБ-ны вэбсайт дээр мэдээлэх |
| Tendering Тендер | Жаргалант сумын АТН, тендерт оролцогч ААН | Тендерийн баримт бичиг, барилгын ажлын гэрээ болон гүйцэтгэгчийн барилгын менежментийн төлөвлөгөөнд нөлөөллийг бууруулах арга хэмжээ, БОМТ-ний талаарх АХБ, ЗГ-ын заалтуудыг тусгах |
| | Жаргалант сумын АТН, ТХХТЗБ-БООУМ | БОМТ-г Нарийвчилсан зураг төсөлтэй уялдуулж шинэчлэнэ. Шинэчилсэн БОМТ-г ТХХТЗБ-т өгнө. |
| Барилга угсралт | ГА болон ГАХ | ГА дэмжиж ажиллах |
| | ГА болон Жаргалант сумын АТА | Нөлөөлийг бууруулахад арга хэмжээний талаар зөвлөлгөө дэмжлэг үзүүлж ажиллах |
| | ХА, Жаргалантын Аймгийн төслийн нэгж<br>Гүйцэтгэгчид | Нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар зөвлөгөө өгөх<br>АХБ, ЗГ-ын БОМТ-ий шаардлагыг бүрэн хангасан Гүйцэтгэгчийн БОМТ-г (ГБОМТ) бэлтгэж ирүүлэх.<br>Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шинжилгээ / хяналт хийх. |
| | БОХА/ УБ хотын ТН, Жаргалантын БОХА/ ТМА | Санал гомдол барагдуулах механизмыг зохицуулах, БОМТ-ийн хэрэгжилтэд хяналт тавих, барилгын талбайд тогтмол хяналт шалгалт хийх, БОМТ-ний ажлын явцын тайланг сар бүр гаргах, сургалт явуулах, Байгаль орчны хяналт шинжилгээний жил тутмын тайланг боловсруулахад нь ТХХТЗБ-т дэмжлэг үзүүлэх. |
| | БОНҮ хийх эрх бүхий ААН | Байгаль орчны хяналт шинжилгээг улирал бүр гүйцэтгэх, тайлан бэлтгэх |
| | ТХХТЗБ-БООУМ | Нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар зөвлөгөө өгөх, Байгаль орчны менежментийн чиглэлээр ХХН-д иж бүрэн техникийн дэмжлэг үзүүлэх, сургалт явуулах, БОМТ-г дагаж мөрдөж буй талаар хяналт шалгалтыг жил бүр хийх, Байгаль орчны хяналт шинжилгээний жил тутмын тайланг бэлтгэх. |

| Үе шат | Хариуцах байгууллагууд | Байгаль орчны чиглэлээр хариуцах үүрэг |
|---|---|---|
| | ADB АХБ | Conduct review missions, review and approve annual EMP monitoring and progress report, including disclosure Хяналт хийх баг ажиллуулах, мэдээлэл түгээх болон БОМТ-ний явц, тайланг хянаж шалгах. |
| Үйл ажиллагаа Ашиглалт | Жаргалантын Аймгийн төслийн нэгж | БОМТ-г дагаж мөрдөж буй талаар хяналт хийх, байгаль орчны менежментийн шаардлагын талаар ХА-т зааварчилгаа өгөх, Төслийн эцсийн тайлан бэлэн болтол БОМТ-ний хяналт, явцын тайланг бэлтгэж байна. |
| | БОНҮ хийх эрх бүхий ААН | Батлагдсан байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ явуулах |
| | АХБ | БОМТ-ний хяналт шинжилгээ, явцын тайланг хянан баталж, АХБ-ны төслийн вэбсайтад мэдээлнэ. |

ADB = АХБ = Азийн хөгжлийн банк, УБ хотын – ТХН –ийн БОХМ= Байгаль Орчны Хамгааллын Мэргэжилтэн, АТН = Аймгийн төслийн нэгж, ТХХТЗБ = Төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих зөвлөх баг, БООУМ = Байгаль орчны олон улсын мэргэжилтэн, Улаангомын ТХН-ийн Байгаль Орчны мэргэжилтэн, ХХА = БХБЯ-ны Хөтөлбөр хэрэгжүүлэх агентлаг, ХА = Хэрэгжүүлэгч агентлаг (БХБЯ), БОАЖЯ = Байгаль орчин Аялал жуулчлалын Яам, БОННҮ = Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, БОТБҮ = Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, БОМТ = Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, БОХШТ = Байгаль орчны хяналт шинжилгээний тайлан

18. Нөлөөлөлд өртөж буй олон нийтийн зүгээс Ховд аймаг дахь АТН-тэй хамтран дараах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож туслах ба мөн үр өгөөжийг хүртэнэ. Үүнд: (a) 1-р ээлжийн БОТБҮ, Ховд аймгийн БОМТ-г олон нийтэд нээлттэй болгох, аймгийн БОМТ-ний орчны хяналт шинжилгээний тайланд мэдээлэлд өгөх, (b) 1-р ээлжийн төслийг хэрэгжүүлснээс үүдэн гарах эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөллийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх; (в) Барилгын ажил эхлэхийн өмнө эрүүл мэнд, аюулгүй байдлын суурь өгөгдөл, мэдээлэл цуглуулах; (d) гүйцэтгэгчийн зүгээс хийсэн байгаль орчны хяналт шинжилгээний үр дүн, тайланг шаардлагатай бол хянаж шалгах, Жаргалант сумдын иргэдийн хурлын байранд дэлгэж тавьсан байх (e) Гүйцэтгэгчийн хайхрамжгүй байдлаас үүдэлтэй нь тогтоогдсон байгаль орчин/нийгмийн чиглэлээр илэрсэн зөрчлийг засч залруулах шаардлагатай арга хэмжээг авахуулах. Орчны хяналт шинжилгээний талаарх бэлэн байгаа мэдээлэл, ГБМ болон дээр дурдсан нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн оролцоо зэрэг нь гэрээт гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлд олон нийтийн шууд оролцоог хангаж өгөх болно.

19. Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө шаардлагатай нэмэлт суурь мэдээлэл цуглуулах, БОМТ-ний Хяналтын төлөвлөгөөний дагуу барилгын ажлын болон ашиглалтын үе шатуудад байгаль орчны улирлын хяналт шинжилгээ хийх ажлыг БОНҮ хийх эрх бүхий ААН-ээр гүйцэтгүүлнэ. (Хүснэгт 4). Энэхүү эрх бүхий ААН нь байгаль орчны өгөгдөл мэдээллийг цуглуулах болон хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсын чанарын баталгаа, хяналтын талаарх дүрэм, журмыг дагаж мөрдөх ба орчны агаар, ус, дуу чимээний чанарын стандартад нийцэж буй эсэхийг үнэлнэ. Эрх бүхий ААН нь байгаль орчинд нөлөөлөх байдлын хяналтын тайланг Жаргалант дахь ТХН -д улирал тутамд гаргаж өгнө.

20. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөх багийн (ХХТЗБ) байгаль орчны олон улсын мэргэжилтэн (БООУМ) нь БОХА болон АБОХА-ний дэмжлэгтэйгээр 1-р ээлжийн БОМТ-г хэрэгжүүлэхэд нь зориулж ГАХ ба ГА-т “биечилсэн” сургалт явуулах, техникийн чиглэл зөвлөлгөө өгөх үүрэгтэй байна. ТХХТЗБ-ийн БООУМ нь БОХА/АБОХны дэмжлэгтэйгээр (а) нарийвчилсан зураг төсөл, төслийн бэлтгэл, (б) сургалт, (в) тухайн жилд гарсан байгаль орчны ахиц дэвшил, БОМТ-ний биелэлтэд хяналт тавих, (г) БОМТ-ний жил тутмын хяналт шинжилгээ, явцын тайлан (д) хэрэгжүүлэлтийн явцад байгаль орчинтой холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай засаж залруулах арга хэмжээг тодорхойлох (е) шаардлагатай бол газар дээр нь үзлэг шалгалт хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.

A
U
T
O
N
U
M

## III. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛҮҮДИЙН ТУХАЙ ТОВЧ ДҮГНЭЛТ

Азийн хөгжлийн банк (АХБ) нь зөвшөөрөл өгөх зориулалтаар холбогдох баримт бичгүүдийг нягтлан үзэх ба 1-р үе шатны хэрэгжилттэй холбогдох асуудлууд үүний дотор байгаль орчны асуудлыг хянах зорилгоор тогтмол хяналт шалгалтын багийг ажиллуулна. Тухайлбал 1-р үе шатны нарийвчилсан зураг төсөл боловсруулах үе шатанд шинэчилсэн БОМТ болон түүний дараагаар хэрэгжүүлэх шатанд хийгдэх байгаль орчны хяналтын тайланд (БОХТ) зөвшөөрөл авах ёстой.

A
U
T
O
N
U
M

амьдралын түвшин мэдэгдэхүйц дээшилнэ б/ орчин үеийн агро-үйлдвэрлэлийн хөгжинө. Агро-үйлдвэрлэлийн хөгжил нь (а) мах, хүнсний ногооны үйлдвэрлэлийн чанарыг сайжруулснаар урьд өмнө хүрч чадахгүй байсан олон улсын өндөр үнэтэй зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, ингэснээр хөдөө аж ахуйд суурилсан амьдралын нөхцөл, орлогыг сайжруулах; (б) малын ашиг шимийг сайжруулах замаар малын тоог бууруулж ингэснээр бэлчээрийн даац хэтрэх явдлыг багасган улмаар бэлчээрийг нөхөн сэргээнэ (в) өмнөх арга хэмжээний үр дүнд хүлэмжийн хийн ялгаралтыг эрс бууруулж төсөлд хамрагдасан нутаг орны хүлэмжийн хийн ул мөрийг бууруулна.

23. БОМТ-нд анхаарч тусгасан 1-р үе шатанд АСХХОХ-оос Жаргалантын суманд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг Хүснэгт 3 –т нэгтгэлээ. Эдгээр нөлөөллүүд нь: (i) төслийн төрөл бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн барилга угсралтын ажлын үе шатанд үүсэх хангамжийн богино хугацааны тасалдал, (ii) төлөвлөж буй ундны усны хангамжийг өргөтгөл, малын тэжээлийн аж ахуйд зориулсан шинэ услалтын системийн усны хэрэглээ, шинээр байгуулах мах боловсруулах үйлдвэрүүдийн усны зарцуулалтаас болж үүсэж болзошгүй усны хомсдол (iii) дулааны хангамжийг өргөтгөхтэй уялдаж Өлгий дэх дулааны станцаас гарах утааны ялгаралт нэмэгдсэнээс болж агаарын бохирдол нэмэгдэх зэрэг болно. Барилга угсралтын ажлын явцад үүсэх хангамжийн богино хугацааны тасалдал нөлөөлөл, усны хомсдол, агаар, ус, хөрсний бохирдолд дор дурьдсан Нөлөөллийг бууруулах ба хянан шалгах төлөвлөгөөний дагуу бууруулахад авах арга хэмжээг дор дурдсан болно. .

AUTONUM

**Хүснэгт 3**. **АСХХОХ-ийн болзошгүй нөлөөллүүдийн хураангуй –** Жаргалант сум

Үүнийг АСХХОХ-д зориулж тусад нь боловсруулсан Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан болно. Хүснэгт 3 – т Жаргалант сумын ГЧНШТ-г нэгтгэн харуулав.

| **Барилга угсралтын ажлын өмнөх үе шат** |
|---|
| • Жаргалант суманд Нөхөн төлбөр бүхий газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт явагдахгүй |
| **Барилгын ажлын үе шат** |
| **Гэр хороолол дахь хуучин байшинг буулгах, талбайг цэвэрлэх:**<br>Уламжлалт гэр, модон байшинд асбест зэрэг хорт материал агуулагддаггүй тул 13-р баг болон сонголтоор орж буй 5-р багийн хашаан дахь гэр, байшинг хэсэгчлэн эсвэл бүрэн буулгах явцад хорт материал үүсгэхгүй. Айл өрхийн нүхэн жорлонг устгаж, хөрсөөр дүүргэх ажлыг Улаанбаатар хотод АХБ-наас хэрэгжүүлж буй Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах төслийн мөрдөж буй журмын дагуу гүйцэтгэнэ. Нүхэн жорлонгийн ойролцоох хөрсийг бактери устгах бодисоор шүршиж ариутгана. |
| Шинэ болон өргөтгөж шинэчилсэн газар доогуур тавих хангамжийн шугам сүлжээ (цэвэр, бохир ус, дулаан], ил тавигдах сүлжээ (холбоо, цахилгаан) шинэ болон шинэчилсэн зам, дренаж, усны суваг, голын эрэг далангийн тохижилт, шинэ болон засварлаж өргөтгөсөн барилга (гэр хороолол дахь орчин үеийн сууц, БУЦБ, мах боловсруулах үйлдвэр, лаборатори, сургууль, эмнэлэг, олон нийтийн төв), хог хаях цэгийг цэвэрлэж хашаажуулах ажил:<br>• Барилгын ажлын улмаас үүсэх нийтлэг нөлөө, саад нь дараах байдлаар илэрнэ: i) олон нийт зорчих зам талбай, явган хүний хөдөлгөөнийг хаах, эсвэл багасгах; ii) бизнес болон амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа тасалдах; iii) газар шорооны ажил, хүнд даацын ачааны машин, тоног төхөөрөмжийн ашиглалтаас үүсэх сул тоос шороо; iv) тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний улмаас үүсэх хөрсний бохирдол; v) оршин суугчид болон ажиллагсдын осол, гэмтлийн эрсдэлүүд; vi) замын хөдөлгөөнд саад үүсэх, зам тээврийн осол нэмэгдэх vii) ажилчдын байрлах хотхоноос үүсэх хатуу хог хаягдал, ахуйн бохирдол; viii) явуулын ажилчдаас үүдэлтэй нийгмийн асуудал; ix) соёлын өв, үнэт зүйлс, сургууль, эмнэлэг, олон нийтийн төвд учирч болзошгүй саад доголдол |
| **Хангамжийн үйлчилгээ тасалдах:**<br>• Өлгий болон Дэлүүн суманд дэд бүтэц, шугам сүлжээг засварлах, өргөтгөх ажлын явцад оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдийн хангамжид тасалдал үүсэх нь дамжиггүй. Орон нутагт гарах саад бэрхшээлийг багасгахын тулд тухайн үед нөөц болон туслах төхөөрөмж ашиглах болно. |
| Карьер, шороон ордууд:<br>• Одоо ашиглаж байгаа болон Баян-Өлгий аймгийн Байгаль орчны газраас зөвшөөрөл олгосон карьер, ухлагыг ашиглана. Шинээр ухлага, карьер нээхгүй, ямар ч шинэ газрыг хөндөхгүй, ухлага, карьерыг ашигласны дараа талбайг зохих байдлаар аюулгүй болгож нөхөн сэргээх шаардлагатай гэсэн шаардлагуудыг барилгын ажлын тендерийн баримт бичигт багтаасан болно |

**Асфальт, бетон зуурмагийн үйлдвэр:**

- Асфальт, бетон зуурмаг үйлдвэрлэх түр цехүүд хот суурин газрын дэд бүтцийн ажилд ашиглагдаж болзошгүй. Энэхүү цехүүд нь тухайн газар, орон нутгийн хувьд хүрээлэн буй орчины бохирдлын эх үүсвэр болдог. Элс, бусад агрегат түүхий эд материалын овоолгоос үүсэх салхи, усны элэгдэл (тоос шороо, лаг хурдас) болон зуурмаг үйлдвэрлэх, хүнд даацын тэргээр зөөвөрлөх явцад үүсэх байнгын чимээ шуугиан, хөдөлмөр хамгааллын эрсдэл зэрэг асуудлууд үүснэ. Түүхий эдийг зохисгүй хэрэглэх, хадгалахаас үүдэж цемент дэх бэхжүүлэгч химийн бодис болон асфальт хийх материал дахь нүүрсустөрөгч нь (газрын тос, шингэлэгч зэрэг) хөрсний болон гадаргын усны бохирдол үүсгэж болзошгүй.
- Түр цех байгуулах, ажиллуулах, эцсийн байдлаар буулгаж зөөх ажлыг гүйцэтгэхдээ ийм ажилд хэрэглэдэг сайн туршлагын аргуудыг хэрэгжүүлэх ёстой. Гүйцэтгэгч нь БХБЯ-ны хяналтын дор Дэлхийн Банкны (ОУСК) EHS удирдамжид заасан 1) цемент, шохой үйлдвэрлэх, 2) Барилгын материал олборлох; 3) Газрын тосны жижиглэнгийн сүлжээ гэсэн олон улсын дүрэм журмыг баримтлах ёстой. Саяхан батлагдсан АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн (USEPA 2014) Бетон зуурмагийн үйлдвэрлэх практикийн журмыг мөн ашиглаж болно.

Ахуйн хэрэгцээний усан хангамжийн тасалдал:

- Жаргалант суман дахь ахуйн ус түгээх цэг, худгаас хэрэгцээний усыг зөөдөг өнөөгийн практик нь барилгын ажлаас шалтгаалж амархан тасалдаж болзошгүй.

Dumpsite rehabilitation: Үерээс хамгаалах далангийн сайжруулах:

- Төслийн 1-р үе шатанд Жаргалант суман дахь хогийн цэгүүдийн үйл ажиллагааг хамруулсан хатуу хог хаягдлын менежментийн нарийвчилсан үнэлгээ хийж гүний усны түвшин, чанарыг тогтооно. Хог хаягдал салхинд тарж хийсч байгааг зогсоох мөн урьдчилан сэргийлэх зорилгоор одоо байгаа хогийн цэгүүдийг цэвэрлэж, хашаажуулна. Хогийн цэгүүдийн байршил дахь гүний усны түвшин, усны чанарт үнэлгээ хийх нь хог хаягдлаас шалтгаалж гүний ус бохирдож буй эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой

**Ашиглалтын үе шат**

Төслийн 1-р үе шатанд Дулааны станцаас гарах утааны найрлагыг олон улсын стандартад (ж-бэл: ОУСК-БОЭМААУ, ДЭМБ 2007) нийцүүлэх арга хэмжээ авахгүй бол Жаргалант суман төвлөрсөн дулаан хангамжийг өргөтгөснөөр агаарын бохирдлыг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй юм.

Өргөтгөж буй ундны усан хангамжид зориулж гүний усыг нэмж олборлох, мах боловсруулах үйлдвэр болон услалтын системд зориулж гүний ба гадаргын усны шинээр олборлох нь Жаргалант суман дахь төслийн бүрэлдэхүүн хэсгүүд болон усны эх үүсвэрээс “доош” орших хэрэглэгчдэд усны хомсдол үүсгэж болзошгүй юм. ТЭЗҮ-ийн судалгаагаар тогтоосон төслийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн усны хэрэгцээ болон орчны усны хүрэлцээний тооцоог нарийвчилсан зураг төслийн үе шатанд баталгаажуулах шаардлагатай

Усалгаатай талбайгаас гарах урсацыг цуглуулах зорилгоор төлөвлөсөн талбайн дагуух мод бут тарьж ургамалжуулсан суваг шуудуу нь бордсон талбайгаас гарсан усыг талбайгаас доошхи хэсгийн гадаргын ус руу оруулахгүй барьж байгаа эсэхийг шалгаж байх зорилгоор Жаргалант сум орчмын услалтын системээс доошхи гадаргын усны чанарт хяналт тавьж байх. (IFC-EHS 2007).

# IV. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

A
U
T
O
N
U
M

1

Жаргалант суманд зориулж боловсруулсан оролцогч талуудтай зөвшилцөх хөтөлбөрийг 1-р үе шатны зураг төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах хоёр байршилд хамрагдсан талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтаар эхлүүлсэн. Үүний дараагаар БОТБҮ-ний эхний хувилбарыг өмнөх

ил тод мэдээллээр хангах, тэдэнтэй зөвлөлдөх ажлыг барилга угсралтын ажил эхлэхээс өмнө болон барилгын ажлын үе шатанд ГБМ-аар (G бүлэг дэх БОТБҮ) үргэлжлүүлнэ.

AUTONUM

Төслийн 1- р шатанд төсөлд оролцогч талуудын бүрэн гүйцэт оролцоо, тэдэнтэй зөвшилцөх зэргийг амжилттай сайн хэрэгжүүлэх амин чухал зүйл нь оролцогч талуудын оролцоо, ажлын үр дүнд хяналт шалгалт явуулж байх. Барилгын ажил эхлэхээс өмнөх нарийвчилсан зураг төсөл боловсруулан гаргах үе шатанд ТХХТЗБ нь Улаанбаатар хот дахь ТХН, ХА, (БХБЯ) -тэй хамтран оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг эцэслэн боловсруулана. Барилгын ажлын үе шатны туршид төслийн оролцогч талуудын оролцоо болон өргөдөл гомдлын механизмын хэрэгжилтийг ТХХТЗБ нь Улаанбаатар хот дахь ТХН болон бусад гурван аймгийн АТА -тэй хамтран хяналт мониторинг хийж байна. Төслийн 1- р шатны үйл ажиллагаа хэрэгжиж дуусахад БХБЯ болон Монгол Улсын Хөгжлийн Банк нь төслийн гурван аймгуудын засаг даргын тамгын газартай хамтран төсөлд хамрагдсан сум суурингийн иргэд олон нийт болон малчидтай зөвшилцөн тасралтгүй оролцоог хэрхэн хангаж ажилласан талаар хяналт дүн шинжилгээ хийнэ. Төслийн гурван аймгуудын засаг даргын тамгын газар нь хяналт дүн шинжилгээ мониторинг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

## V. НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

AUTONUM

AUTONUM

БОМТ-ний нөлөөллийг бууруулах арга хэмжээг дараахь хүснэгтэд цогц байдлаар тусгалаа. БОТБҮ-ний нэг адилаар нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний бүтцийг АСХХОХ-ийн гурван үе шат болох барилга угсралтын ажлын өмнөх, барилгын ажлын, ашиглалтын гэсэн гурван үе шатны дагуу хийсэн болно. Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт дээр хөндөгдөж яригдсан байгаль орчны талаарх санал, асуудлыг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд тусгасан.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд дэд бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд түгээмэл тохиолддог барилга угсралтын ажлын үе шатны нөлөөллийг хамтруулан авч үзэж бууруулах арга хэмжээг нь нэгтгэн зааж өгсөн болно. Ингэснээр нөлөөллийг бууруулах нийтлэг арга хэмжээг олон удаа давтаж хэлэхээс зайлсхийсэн. Гэхдээ дэд бүрэлдэхүүн хэсэгт онцолж хамаарагдах нөлөөлөл болон шаардлагатай бууруулах арга хэмжээг тодорхойлж, байгаль орчин эсвэл соёлын бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөллийг бууруулахад онцгой ач холбогдолтой нийтлэг арга хэмжээг шаардлагатай үед онцлон тэмдэглэв.

29. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд болзошгүй нөлөөлөл, бууруулах шаардлагатай арга хэмжээ, хариуцах талууд, байршил, цаг хугацаа, зардлын тойм хэмжээг тодорхойлдог. Дээр БОМТ-ний Байгууллагуудын зохицуулалт хэсэгт тайлбарласанчилан ХХН – ГЗБГЗЗГ нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтын байгаль орчны менежментийг хариуцлаг бол ХХН-БАҮХ нь агро-үйлдвэрлэл, бэлчээрийн хэсгийн байгаль орчны менежментийг хариуцах болно. ХХН-ХҮК нь хувийн хэвшлийн бүх хөрөнгө оруулалтын менежментэд шууд болон Хас банк, ХААН банк гэсэн санхүүгийн зуучлагчдаар дамжуулан хяналт тавина. Жаргалант сумын 1-р үе шатны эцсийн нарийвчилсан зураг төслийн дагуу хялбар дөхөм шинэчилж болохуйц байхын тулд нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээг өргөн хүрээтэй авч үзсэн болно.

# Хүснэгт 4.  Нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хяналт** | **Гүйцэтгэл** |
| ***Дэд бүтэц болон Агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгийн нарийвчилсан зураг төслийн болон барилга угсралтын ажлын өмнөх үе шат*** | | | | | | | | |
| Шаардлагатай нүүлгэн шилжүүлэлт ба нөхөн олговрын баталгаажуулалт | Байгаль орчинд сөрөг нөлөөгүй | 1.АСТБХХОХ-ийн хэрэгжилтийн талаар Алагтолгой багийн айл өрхүүдийг сайтар мэдээллээр хангах. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн журам, хуваарийг эхний уулзалтаас өмнө хамрагдаж буй багуудад тарааж өгөх ёстой. | Бүх аймгийн төсөлд хамрагдаж буй газруудад байгаа нөлөөнд өртөж буй бүх хүмүүс | Төсөл хэрэгжиэхээс өмнө | ГЧНШТ-г үзнэ үү | ГЧНШТ-г үзнэ үү | ХХН | ГЧНШТ хороо |
| Алагтолгой багийн гэр хорооллын дахин төлөвлөлтөд хамрагдах хэмжээг эцэслэж тогтоох | Хамрагдаж байгаа болон хамрагдаагүй иргэдэд сөрөг нөлөөгүй | | | | 1-р ээлжийн нарийвчилсан зураг төслийн (НЗТ) тайлангийн нэг хэсэг болгож | Нэмэлт зардал байхгүй | | хХН |
| Мэдээллийг нээлттэй болгож олон нийтийн оролцоог хангах | Оршин суугчдад үзүүлэх нөлөө байхгүй | 2. Оршин суугчдад БОТБҮ-ний мэдээллийг тараах, гомдол барагдуулах механизмыг эхлүүлэх | Барилга угсралт явагдах бүх талбайд | Төслийн эхэнд | Улирал тутам, дараачийн олон нийтийн хурлын тайлан гартал | Нэмэлт зардал байхгүй | ХХН | ХХН/ТХХТЗБ |
| ЗГ-ийн зөвшөөрөл | Сөрөг нөлөөгүй | 3. БОНБҮ-ний шаардлагыг бүрэн хангахын тулд төслийг эхлүүлж байгаа талаар БОАЖЯ-нд мэдэгдэж, шаардлагатай зөвшөөрөл, гэрчилгээ авах. | Бүх байршлуудад | Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө | ТХН-ийн тайлан гаргах шаардлагын дагуу | Нэмэлт зардал байхгүй | ХХН/БОАЖЯ | ТХХТЗБ-БООУМ |
| Найдвартай усан хангамжийн үнэлгээ | Төсөлд болон бусад хэрэглэгчдэд усны хангамж хүрэлцэхгүй болох | 4. Их хэмжээний ус шаардагдаж болзошгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн байршилд (мах боловсруулах үйлдвэр г.м) орон нутгийн гүний болон гадаргын усны хүртээмжийг бага урсацтай үед (гидро-геологи) үнэлгээгээр тогтоож баталгаажуулах.<br>5. Ус авах цэгээс доош орших хэрэглэгчдийн усны хэрэгцээг үнэлж тогтоох | Бохир ус цэвэрлэх байгууламжийн хамрах талбай, агро паркуудын орчим | Ус хэрэглэгч хэсгүүдийн хэмжээг эцсийн байдлаар тогтоохоос өмнө | НЗТ болон НЗТ-ийн тайланд тавих шаардлагын дагуу<br>(дор 6.ix-ийг үзнэ үү) | Нэмэлт зардал байхгүй | ТХХТЗБ/ХХН | ТХХТЗБ |
| 1-р ээлжийн зураг төслийг боловсруулж дуусах | Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах | 6. Бүрэлдэхүүн хэсгүүдийн НЗТ-ийг ТХХТЗБ-тэй хамтарч боловсруулах<br>Дараах арга хэмжээг тусгах:<br>**i.** барилгын бүх талбайд түлш, химийн | | | | | | |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | бодис асгарахаас сэргийлэх, онцгой байдлын үед авах арга хэмжээний менежмент<br>**ii.** соёлын өв, үнэт зүйлсэд эдрэл гэмтэл учруулахгүй байх<br>**iii**. мод ургамлыг шаардлагагүйгээр огтлохгүй байх<br>**iv.** байгаль орчны газраас зөвшөөрөл авсаны дараа төв суурин газраас зайтай байршилд хашаа хамгаалалт бүхий карьер байгуулах<br>**v**. гэр хорооллын туршилтын гудамж болон барилгын талбайн зам дагуу явган хүн, болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх талаар эртнээс төлөвлөх, онцгой үед ашиглах туслах зам гаргах<br>**vi**. айл өрх, нийтийн аж ахуй, арилжааны үйл ажиллагааны тасалдлыг багасгах зорилгоор оршин суугчид болон бизнес эрхлэгчдэд барилгын ажлын тухай болон ажил хийгдэх хуваарийн талаар мэдэгдэл хүргүүлэх тусгай төлөвлөгөө гаргах, мэдээлэх<br>**vii.** нөлөөлөлд хамрагдаж буй сургууль, соёл, олон нийтийн төвүүдийн хангамж тасалдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах<br>**viii.** бүх барилгын талбайг нөхөн сэргээх, сайжруулах төлөвлөгөө<br>**ix.** ус хэрэглэх бүрэлдэхүүн хэсгүүдийн хэмжээ далайцыг орчны усны эх үүсвэрийн урсацын бага үе дэх хэмжээ болон ус авах цэгээс доошхи хэрэглэгчдийн хэрэгцээтэй таарч тохирсон бөгөөд тогтвортой байхаар тооцох | Байршлыг эцэслэн тогтоох | Барилгын ажил эхлэхээс өмнө | Шинэчилж боловсруулсан зураг төсөлтэй хамт нэг удаа | Нэмэлт зардал байхгүй | ТХН | БОНҮ хийх эрх бүхий ААН |
| БОМТ-г шинэчлэх | Байгаль орчинд эерэг нөлөөтэй | 7. Шинэ болон өргөтгөх бүх дэд бүтцийн шугамын (хангамжийн шугам | | | | | | |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | хоолой, авто зам, цахилгаан дамжуулах шугам, агро парк хүртэлх усны суваг г.м.) эцсийн байршлыг нягталж хянах, ойр орчмд буй эд хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг бууруулах, сэргийлэх зорилгоор барилгын ажлын нөлөөллийг бууруулах арга хэмжээг шинэчлэх.<br>8. Мал эрүүлжүүлэх төв, агро парк зэрэг шинэ болон сэргээн засварласан барилга байгууламжийг хянаж зэргэлдээ орших эд хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг бууруулах, сэргийлэх зорилгоор барилгын ажлын нөлөөллийг бууруулах арга хэмжээг шинэчлэх<br>9. Үерээс урьдчилан сэргийлэх далангийн эцсийн сайжруулалтыг нягталж үзэх, элэгдэл болон лаг үүсэхээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг шинэчлэх<br>10. Төсөлд хамаарах дулааны станц болон бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир ус, агаарт ялгаруулах утааны чанар нь ОУСК-БОЭМААУ стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах<br>11. Жаргалантад баригдах хатуу хог хаягдлын цэгийн байршлыг Байгаль орчны газартай хамт шийдэх<br>12. 1-р ээлжид үүсч болзошгүй аливаа /шинэ нөлөөллийг олж тогтоон БОМТ-нд нэгтгэх<br>13. Олж тогтоосон аливаа шинэ боломжит нөлөөллийг хамтруулсан, шинэчилсэн БОМТ-г хянуулахаар БХБЯ, АХБ-нд хүргүүлэх. | Жаргалант дахь бүх байршилд | Барилгын ажил эхлэхээс өмнө | Шинэчилсэн БОМТ-ний хамт нэг удаа | Дор буй хяналт шинжилгээний төлөвлөгөөг үзнэ үү | ТХН / БОНҮ хийх эрх бүхий ААН | ТХХТЗБ-БООУМ |
| | | 14. ГБОМТ-д ашиглах нөлөөллийг бууруулах менежментийн дэд төлөвлөгөөг тодорхой болгох. Үүнд: а) Барилгын ус зайлуулах дренаж; б) Хөрсний элэгдэл; в) Дуу чимээ ба тоос шороо; г) Бохирдсон хөрс | | | Шинэчилсэн | | ХХН / БОНҮ | |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | зайлуулах; д) барилгын хатуу болон шингэн хог хаягдлыг зайлуулах; е) Барилгын ажлын болон хотын замын түгжрэл; ж) хангамжийн шугам хоолой, эрчим хүчний тасалдал; з) Ажилчдын болон олон нийтийн аюулгүй байдал; и) Мод, ургамлан нөмрөгийг зайлуулах, талбайг нөхөн сэргээх; к) Барилгын материал худалдан авах, тээвэрлэх, хадгалах; л) Соёлын санамсаргүй олдвор.<br>Санамсаргүй олдворын үед ажиллах журмыг НЗТ-ийн явцад дахин хянаж үзэж хангамжийн шугам хоолой болон бусад бүх дэд бүтцийн эцсийн зураг төсөлд газар шорооны ажлын байршлуудыг оруулсан эсэхийг шалгах ёстой.<br>15. Алагтолгой багт зориулсан нөлөөллийг бууруулах дэд төлөвлөгөөг эцэслэн гаргах ба үүнд хашаан дахь байшинг буулгах, талбай болон хөрсийг цэвэрлэх, хашаанд байгаа үлдэгдэл нүүрс, хуучин гэр ахуйн цахилгаан хэрэгслийг устгах ажлууд орох ёстой. Дэд төлөвлөгөө нь ажилчдын болон олон нийтийн аюулгүй байдлын төлөвлөгөөний нэг хэсэг байж болно.<br>16. Буулгасан хашаа байшингийн нурангид байж болох аливаа асбестыг зайлуулах тусгай төлөвлөгөө хийгдсэн байх ёстой.<br>17. БОМТ-г шинэчлэх өртөг. | | Барилгын ажил эхлэхээс өмнө | БОМТ-ний хамт нэг удаа | Дор буй хяналт шинжилгээний төлөвлөгөөг үзнэ үү | хийх эрх бүхий ААН | ТХХТЗБ-БООУМ |
| Засгийн газраас зөвшөөрсөн барилгын хог хаягдлын цэгийг баталгаажуулах | Сөрөг нөлөөгүй | 17. Жаргалант дахь барилгын ажилд зориулсан карьер болон хог зайлуулах цэгүүдийн байршлыг баталгаажуулахаар Байгаль орчны газарт мэдэгдэх ба шаардлагатай зөвшөөрөл авах. | Жаргалант дахь бүх талбайд | Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө | Шаардлагын дагуу ТХН-ийн тайланд | Нэмэлт зардал байхгүй | ХХН/БОАЖЯ | ТХХТЗБ-БООУМ |
| Тендерийн баримт бичгийг | Сөрөг нөлөөгүй | 18. Гүйцэтгэгчийн бэлтгэсэн тендерийн саналд шинэчлэгдсэн | Жаргалант дахь бүх талбайд | Барилга угсралтын | Тендерийн бүх баримт бичигт | Нэмэлт зардал | АХБ/ТХН/ SRA | ТХХТЗБ/Тендерт орж буй ААН |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| боловсруулах | | БОМТ-г тусгасан байх, мөн гүйцэтгэгчийн тодорхойлсон ГБОМТ төсөвлөгдөж орсон байх ёстой.<br>19.Тендерийн баримт бичигт гүйцэтгэгч нь ГБОМТ-г боловсруулах, хэрэгжүүлэх туршлагатай, эсвэл туршлагатай ажилтнаар хангах чадвартай байх талаар зааж өгнө. | | ажил эхлэхээс өмнө | нэг удаа | байхгүй | | |
| Тухайн орон нутгийн ард иргэдийн соёлын биет өвийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх | Сөрөг нөлөөгүй | 20. ТХН/ТХХТЗБ-с соёлын биет өвийн боломжит байршлыг шалгаж, гэрээт гүйцэтгэгчдэд энэ талаар тайлбарлана | Жаргалант дахь бүх талбайд | Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө | ТХН-ийн тайланд нэг удаа | Нэмэлт зардал байхгүй | ХХН | ТХХТЗБ-БООУМ |
| Холбогдох зөвшөөрөл, тусгай зөвшөөрлүүдийг авч, хүчинтэй болгох | Нөлөөг багасгах буюу урьдчилан сэргийлэх | 21. Гүйцэтгэгч нь барилгын тоног төхөөрөмж ашиглах, бетон зуурмаг зэрэг барилгын ашиглалтын үйлдвэрийг ажиллуулахтай холбогдуулж Монгол улсын Засгийн газраас тавьсан бүх шаардлагыг биелүүлэх. | Барилга угсралтын бүх талбайд | Барилгын ажлын эхэнд | ТХН-ийн тайланд нэг удаа | Нэмэлт зардал байхгүй | ХХН/SRA | ТХХТЗБ/гүйцэтгэгч |
| Чадавхийг бэхжүүлэх | Сөрөг нөлөөгүй | 22. БОМТ-г бүрэн гүйцэд хэрэгжүүлэхийн тулд ТХН / ТХХТЗБ-БООУМ-с сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хуваарь гаргах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэгчийн зүгээс хийх ажлыг удирдан зохион байгуулах.<br>23. Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчдэд зориулсан мэдлэг, сургалтын төлөвлөгөөг боловсруулах | Жаргалант дахь бүх талбайд | Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө | Анхан шатны сургалт, ТХН-ийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан бол давтан сургалт | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | ТХХТЗБ |
| Ажилчид элсүүлэх | Бэлгийн замын халдварт өвчний тархалт | 24. Ажилчдыг орон нутгаас аль болох өргөнөөр элсүүлснээр явуулын ажилчдын тоог багасгах | Бүх ажиллах хүч | Барилгын ажлын бүх үе шатанд | Худалдан авалтын төлөвлөгөөний тайланд ажилчид элсүүлэх үе шатыг оруулах | Нэмэлт зардал байхгүй | ХХН | Гүйцэтгэгчийн тендерийн санал |
| ***Хот суурины болон Агро-үйлдвэрлэлийн хэсгийн дэд бүтцийн барилга угсралтын үе шат*** | | | | | | | | |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| БОМТ болон дэд төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх | Нөлөөллийг багасгах, урьдчилан сэргийлэх | 25. Барилга угсралтын өмнөх үе шатанд хийгдсэн нөлөөлөл үүсэж болзошгүй төрөл бүрийн хэсэгт менежментийн дэд төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх зэргээр шинэчилсэн БОМТ ба ГБОМТ-г эхлүүлэх (дэд төлөвлөгөөний удирдамжийг доор үзнэ үү) | Барилгын бүх талбайд | Барилгын ажлын эхлэх үед | Хамгийн анхны Нөлөөллийг бууруулах ажлын тайланд | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |
| Ажилчдын байр/хотхоны үйл ажиллагаа | БЗХӨ, хэрүүл маргаан, зодоон, дээрэм зэрэг нийгмийн асуудлууд, Байгаль орчны бохирдол | 26. Ажилчдын хотхоныг хот сууринаас зайтай байрлуулах<br>27. Нүхэн жорлон, хогийн сав зэргээр хангасан зохистой байр сууц, хог хаягдлыг цуглуулах байгууламжаар хангах<br>28. Ажилчдын хотхоыг цэвэр байлгахын тулд хатуу хог хаягдлыг цуглуулах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх<br>29. Эрэгтэй эмэгтэй ажилчдад тусад нь зориулсан нүхэн жорлонг ажилчдын амьдрах болон хооллох байрнаас зайтай байрлуулах<br>30. Нүхэн жорлонг байнга ашиглах боломжтой байхаар цэвэрлэгээ хийх, ариутгал хийх хуваарь гаргаж хэрэгжүүлэх<br>31. Ажилчдын хотхонд зохих шаардлага хангасан дренаж байх ёстой | Түр зуурын ажилчдын байр/хотхон, талбай | Барилга угсралтын ажлын туршид | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |
| | | Ажилчдын хотхонд орон нутгийн хоол хүнсийг нийлүүлэх нь зүйтэй.<br>32. Ажилчдын хотхонд буу зэвсэгийг хориглоно.<br>33. Явуулын ажилчид орон нутгийн иргэдтэй харилцахгүй байх ёстой. Ажилчдад ДОХ/ХДХВ-ээсхамгаалах тухай сургалт явуулах<br>34. Барилгын ажил дууссаны дараа ажилчдын хотхоны талбайг анхны байдалд нь оруулж нөхөн сэргээлт хийх ёстой. | | | | | | |
| Сургалт ба чадавхийг сайжруулах | Сургалтаар дамжуулан нөлөөллөөс урьдчилан сэргийлэх | 35. ТХН / ТХХТЗБ-БООУМ-с гүйцэтгэгчдэд зориулан сургалт мэдлэг дээшлүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлэх | ТХН-ийн офис, барилгын талбайд | Барилгын ажил эхлэх үед | Сургалт бүрийн төгсгөлд ТХН-ийн нөлөөллийг бууруулах ажлын тайланд | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | ТХХТЗБ-БООУМ |
| Барилгын материалын карьерын үйл | Бохирдол, бэртэл гэмтэл, машин механизмын | 36. Сонгосон бүх карьеруудыг Байгаль орчны газраас хянаж байх<br>37. Барилгын талбайд аль болох ойр байх | Бүх карьер болон барилгын талбай | Барилгын ажлын туршид | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| ажиллагаа | хөдөлгөөнөөс үүсэх замын түгжрэл | налуу багатай газрыг сонгох<br>38. Хаягдал үүсэхээс сэргийлэх зорилгоор олборлолт эхлэхээс өмнө шаардагдах материалын нийт эзлэхүүнийг нарийн тооцох шаардлагатай<br>39. Карьер нь гадаргын ус, байшин барилга, соёлын дурсгалт зүйл болон өвийн ойролцоо байрлах ёсгүй.<br>40. Карьер нээхэд зайлуулсан бүх шимт хөрс, болон түүний доод үеийг дараа нөхөн сэргээлт хийхэд зориулан овоолж нөөцөлсөн байна.<br>41. Бүх карьер болон ухсан нүхний гадуур иргэдэд анхааруулсан тэмдэглэгээ хийж, хашлага тавина.<br>42. Ашиглаж дууссаны дараа, ухсан нүх карьерийн усыг шавхан гаргаж, ард иргэд, мал амьтдыг хамгаалах зорилгоор байнгын хашаа барих ёстой бгөөд анх хуулсан хөрс чулуулгийг ашиглан аль болох боломжит хэмжээгээр нөхөн сэргээлт хийх хэрэгтэй.<br>43. Олборлолтын улмаас карьерт болон түүний ойролцоо үүссэн налууд мод тарьж тогтворжуулах. | | | | | | |
| Барилгын материалын тээвэрлэлт ба тэдгээрийг барилгын дээр хадгалах | Бохирдол, бэртэл гэмтэл, машин механизмын хөдөлгөөнөөс үүсэх замын түгжрэл | 44. Материалыг карьераас олборлох, тээвэрлэх, ашиглах, хадгалахыг тодорхойлсон хуваарь гаргах<br>45. Ган, модон бүтээц зэрэг боловсруулсан материал, ажлын шатыг хэрхэн тээвэрлэх, угсрах, ашиглахыг тогтоож, хуваарь гаргах<br>46. Элс хайрга зэрэг задгай ачааг заавал бүтээж тээвэрлэнэ.<br>47. Талбай дээрх завгай овоолгыг нэн даруй ашиглаж, зайлуулж байх, эсвэл замын хөдөлгөөнгүй талбайд бүтээж хадгална.<br>48. Задгай материалыг хүний үйл ажиллагаа, хот суурин газар, соёл экологийн обьектоос хол зайд хадгална. Асфальт зуурмагийн үйлдвэр, ашиглалтын талбайг орон сууцны болон арилжааны бүсээс тусгаарлана. | Бүх барилгын талбай | Барилгын ажлын туршид | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |
| Асфальт үйлдвэрлэл, | Агаар, хөрс ус бохирдох, замын | 49. Асфальт үйлдвэрлэх, тээвэрлэх, ашиглах ажилд гүйцэтгэгч нь маш сайн туршлагатай | Бүх барилгын | Барилгын ажлын туршид | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| хэрэглээ | хөдөлгөөний асуудлууд | байх ёстой.<br>50. Асгарсан бүх шингэнийг аюултай хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, ЗГ-с заасан журмын дагуу нэн даруй цэвэрлэж арилгасан байна.<br>51. Асфальтыг зөвхөн заагдсан замын дэвсгэрт асгаж дэвсэх ба түүнээс бусад газар, аливаа гадаргын ус, түүний ойролцоо, мөн хүний амьдардаг газрын ойр орчимд ашиглахыг хориглоно.<br>52. Битумыг түлш болгож ашиглаж болохгүй. | талбай | | | | | |
| Барилгын хаягдлын менежментийн дэд төлөвлөгөө | Карьер гаргаснаас болон барилгын хог хаягдлаас үүссэн хөрс ба гадаргын усны бохирдол | 53. Бохирдоогүй хог хаягдлыг Байгаль орчны газраас тогтоосон цэгт зайлуулах бөгөөд тус цэг нь гадаргын ус, түүний ойролцоо байрлаж болохгүй. Тогтоосон цэгийг тодорхой тэмдэгжүүлсэн байх ёстой.<br>54. Хог хаягдлыг налуу газар, соёлын өв, дурсгалт зүйлсийн ойролцоо, экологийн хувьд чухал газар, эсвэл аливаа бусад соёл, экологийн эмзэг обьектын ойролцоо хаяж зайлуулж болохгүй.<br>55. Боломжтой бол хог хаягдлыг бусад барилгын талбайд ашиглах эсвэл Хог хаягдлын хуулийн дагуу Байгаль орчны газрын зөвшөөрөлтэйгээр хуучин ашиглаж дууссан карьерын нүх руу зайлуулж болно.<br>56. Хог хаягдлын төрөл, тооцсон хэмжээ, зайлуулсан хог хаягдлын эх үүсвэрийг бүртгэж тэмдэглэнэ.<br>57. Бохирдсон хог хаягдлыг зайлуулахдаа ашиглалт, тээвэрлэлт, боловсруулалт (шаардлагатай бол), зайлуулалтын талаар гаргасан ЗГ/БОГ-ын журмуудыг дагаж мөрдөх ёстой.<br>58. Бохирдсон гэж үзсэн сэжигтэй хөрсийг шинжилж, зохих журмын дагуу тогтоосон газруудад устгана.<br>59. Бохирдсон хог хаягдлыг боловсруулах, зайлуулахаас өмнө тэдгээрийг хуванцар уутанд хийж, хүний бүх үйл ажиллагаанаас тусгаарласан байх ёстой. | Ухаж ашигласан бүх талбай | Барилгын ажлын туршид | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Хөрсний бохирдлын шинжилгээ хийх хяналтын төлөвлөгөөг үзнэ үү | ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| Барилгын хатуу болон шингэн хог хаягдлын дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Барилгын хог хаягдлаас хөрс болон гадаргын ус бохирдох | 60. Барилгын хатуу болон шингэн хог хаягдлын менежментийн хүрээнд ЗГ-ын журмуудыг дагаж мөрдөх бөгөөд үүнд барилгын ажлаас болон ажилчдын бий болгосон хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, тээвэрлэх, дахин боловсруулах, зайлуулах ажлууд багтана.<br>61. Хатуу болон шингэн хог хаягдлыг хаях талбайг Байгаль орчны газраас тогтооно.<br>62. Хог хаягдлыг зайлуулахдаа төрөл, тооцсон жин, эх үүсвэрээр нь бүртглэжүүлнэ.<br>63. Барилгын талбайд том хэмжээтэй хогийн сав байрлуулах ёстой.<br>64. Хатуу болон шингэн хог хаягдлыг цуглуулах, зайлуулах хуваарийг гаргах ёстой бөгөөд барилгын талбайг аль болох цэвэр байлгах журмыг мөрдөнө.<br>65. Хатуу хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах хэсгийг нь орон нутгийн худалдан авагчдад зарж борлуулах.<br>**Аюултай хог хаягдал**<br>66. Ашигласан тос, бензин, будаг болон бусад хорт бодисууд зэрэг аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, зайлуулахдаа ЗГ-ын журмыг дагаж мөрдөх ёстой.<br>67. Хог хаягдлыг барилгын талбай, бүх гадаргын ус, усан хангамж, соёл, экологийн мэдрэмтгий бүсээс хол, хаалттай, тэмдэг тэмдэглэгээ бүхий, агааржуулалт сайтай хуванцар саванд хадгалах хэрэгтэй.<br>68. Асгарсан химийн бодисыг бохирдсон хөрснөөс бүхэлд нь цэвэрлэж, бохирдсон хог хаягдлын дэд төлөвлөгөөний дагуу бүрэн зайлуулна. | Барилгын бүх талбай, ажилчдын хотхон | Барилгын ажлын туршид<br><br>Барилгын ажлын туршид | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан<br><br>Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй<br><br>Нэмэлт зардал байхгүй | РМР/ТХХТЗБ<br><br>РМР/ТХХТЗБ | Гүйцэтгэгч<br><br>Гүйцэтгэгч |
| Тоос бууруулах дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Тоосны бохирдол | 70. Гүйцэтгэгчийн тендерийн бичиг баримтад тусгагдаж төсөвлөгдсөний дагуу хөрс болон барилгын талбайн замыг байнга чийгшүүлэх байна.<br>71. Барилгын задгай материал болон ачааны машинуудад ачсан задгай материалыг хучих юм уу чийгшүүлэх. | Барилгын бүх талбайд. | Байнга | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ТХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | 72. Ухлага хийх болон ил гарсан хөрсийг задгай байлгах хугацааг багасгах. Ажил дууссаны дараа нэн даруй буцааж дүүргэх | | | | | | |
| Чимээ шуугиан бууруулах дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Дуу чимээний бохирдол | 73. Зуны улиралд барилгын ажлын үеэр ялангуяа задгай агрегат зөөх үеэр ажлын цагийг 07:00 - 18:00-ийн хооронд аль болох хязгаарлах.<br>74. Тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу ажиллуулах<br>75. Шаардлагагүй их дуу чимээ гаргаж буй машин, төхөөрөмжийг солих.<br>76. Тээврийн хэрэгсэл, машин механизмыг ашиглаагүй үед унтраах.<br>77. Боломжтой бол хэтэрхий их дуу чимээ гаргадаг ажлын талбайд дуу шуугианы эсрэг түр зуурын хаалт барих. | Барилгын бүх талбайд | Байнга | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ТХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |
| Ус, цахилгааны хангамж тасрах үеийн дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Ус, дулаан, цахилгааны хангамж тасрах, тасалдах | 78. Хангамжийн үйлчилгээ тасрах, тасалдах, эсвэл тийм нөхцөл байдал үүсч болзошгүй байршил, хугацааг нарийн тооцож төлөвлөх<br>79. Үйлчилгээ тасрах хуваарийг орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний газарт танилцуулан, тасрах үеийн болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөө боловсруулах.<br>80. Нөлөөлөлд өртсөн хүмүүст төлөвлөсөн тасалдлын талаар мэдээлэх<br>81. Хангамжийн үйлчилгээний бүх тасалдлыг 24:00-с 06:00 буюу бага хэрэглээний үед хуваарилж тохируулах. | Барилгын бүх талбайд | Байнга | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ, Нийтийн ахуйн үйлчилгээний газрын төлөөлөл | Гүйцэтгэгч |
| Мод ургамлыг зайлуулах, талбайг нөхөн сэргээх дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Мод ургамал, ландшафтын эвдрэл гэмтэл | 82. БОАЖЯ/Байгаль орчны газарт хандаж мод, ургамлын гэмтэлийг хэрхэн багасгах талаар зөвлөгөө авах<br>83. Мод, ургамалжилтыг бүхэлд нь зайлуулахдаа зөвхөн зам, дэд бүтцийн байгууламжийн шугам явах хэсгээр хязгаарлах84. Мод зайлуулахаас зайлсхийх, зайлуулах шаардлагагүй модны эргэн тойронд хамгаалалтын биет саадыг суурилуулах.<br>85. Барилгын ажил дууссаны дараа дахин ургамалжуулж, ландшафтыг хэвд нь оруулах | Барилгын бүх талбайд | АСТБХХОХ эхлэх болон дуусахад | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | БОГ/ХХН/ТХХТЗ Б | Гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | бүх талбайд төсөв хуваарилах. Нөхөн сэргээлтийн хамгийн амжилттай стратеги, арга техникийг тодорхойлохын тулд БОАЖЯ/БОГ-тай зөвлөлдөх. Зайлуулсан мод тус бүрт гурван шинэ мод тарих зорилго тавих. | | | | | | |
| Хөрсний элэгдлийг хянах дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Хөрсний элэгдэл | 86. Бүх малталт, газар шорооны ажлын талбайд, ялангуяа Буянт голыг услалтын системээс хамгаалах зорилгоор шаталсан налуу, хуванцар хавтан хашааг байрлуулна.<br>87. Газар шорооны ажлыг хуурай цаг агаартай үед хийх.<br>88. Ухлага хийсэн талбайг буцааж булсны дараа нэн даруй нөхөн сэргээхэд зориулан өнгөн хөрсийг овоолж хадгалах.<br>89. Ил гарсан болон зүсэгдсэн налууг ургамалжуулах замаар хамгаалах, налууг тогтворжуулах төлөвлөгөө бэлтгэсэн байх.<br>90. Ухлагад өртөж ил болсон талбайг ажил дууссаны дараа нэн даруй дахин ургамалжуулах. | Барилгын бүх талбайд | Нийт барилыгн ажлын явцад | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |
| Ажилчид болон олон нийтийн аюулгүй байдлын дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Иргэдийн болон ажилчдын гэмтэл, эрүүл мэнд | 91. Зохих хашаа, хамгаалалтын саад, завсрын бүс зэргийг бүх барилгын талбайн эргэн тойронд болон бүх замын дагуу байрлуулна.<br>92. Барилгын бүх талбайд хангалттай тэмдэглэгээ хийж, мэдээллийн самбар, талбайн хянагч, шөнийн харуулуудыг ажиллуулах ёстой.<br>93. Ажилчдын болон нийтийн аюулгүй байдлын талаарх ЗГ-ын удирдамжийг дагаж мөрдөх ёстой.<br>94. Одоо ашиглагдаж буй замын хөдөлгөөний хэв маяг, барилгын тээврийн хэрэгслийн хэмжээ, төрөлд таарч тохирох хурдны хязгаарыг барилгын тээврийн хэрэгслийн ашигладаг бүх зам дээр тэмдэгээр байрлуулж, дагаж мөрдүүлнэ.<br>95. Өвчин үүсгэх нян үржиж болзошгүй тогтмол ус, шавхайг хөрсөөр дарж битүүлж байх ёстой. | Барилгын бүх талбайд | Байнга | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | 96. Барилгын ажлын үе дэх эрсдэлийн талаар ажилчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх семинарыг барилгын ажлын эхэн үед, мөн сар бүр хамгийн тохиромжтой давтамжтайгаар явуулна. Барилгын талбайн аюулгүй ажиллагааны зааварчлагыг боловсруулж, ажилчдад тараана.<br>97. Барилгын бүх ажилчид зориулалтын хамгаалалтын хувцас, гутал заавал өмсөх ёстой.<br>98. Барилгын бүх талбай дээр эсвэл тэдгээрийн ойролцоо эмнэлгийн зохих үйлчилгээг байх ёстой.<br>99. Бүх барилгын талбайг ундны усаар хангах ёстой.<br>100. Шөнийн цагаар ажиллах шаардлагатай бол хангалттай гэрэлтүүлэг ашиглана.<br>101. Аюултай нөхцлийг арилгахын тулд барилгын бүх талбайд өдөр бүр шалгалт хийх хэрэгтэй. | | | | | | |
| Барилгын ажил | Усны чанар ба орчны усны нөөцийн доройтол | 102. Буянт голын дээр бүх газар шорооны ажил, үерийн суваг, хамгаалалтын далан, хуванцар хашаа, шаврын хамгаалалт байрлуулна.<br>103. Бороонoос үүдэх элэгдэл угаагдлыг тогтоон барихын тулд барилгын ажилд хэрэглэх задгай агрегатуудын овоолгын эргэн тойронд элэгдлийн сувгийг хийнэ.<br>104. Газар шорооны ажлыг цаг агаар хуурай үед хийх хэрэгтэй.<br>105. Газрын тос, дизель түлш гэх мэт барилгын ажилд хэрэглэх бүх шингэнийг Буянт гол болон далангаар боож тогтоосон нуур зэрэг бүхий л гадаргын уснаас хол хадгалж, ашиглах хэрэгтэй.<br>106. Буянт гол болон далангаар боож тогтоосон нуур зэрэг аливаа гадаргын ус руу ямар ч төрлийн хог хаягдлыг хаяж болохгүй.<br>107. Буянт гол болон далангаар боож тогтоосон нуур зэрэг аливаа гадаргын усны ойролцоо машин техник угааж засварлаж | Барилгын бүх талбайд | Нийт барилгын ажлын турш | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | болохгүй.<br>108. Түр нүхэн жорлонг гадаргын ус, гэр орон сууц, бизнесийн байгууллагаас хол зайд байрлуулна.<br>109. Бүх ус зайлуулах суваг, шуудууг , далангаар боож тогтоосон нуур, Буянт голын адилаар хамгаалах болно. | | | | | | |
| Барилгын ажил | Газрын нөөцийн доройтол | 110. Газрын тос, дизель түлш гэх мэт барилгын ажилд хэрэглэх бүх шингэнийг бүхий л гадаргын уснаас хол хадгалж, ашиглах хэрэгтэй. | Барилгын нийт талбайд | Барилгын ажлын явцын турш | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |
| Барилгын болон хот суурины замын хөдөлгөөний дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Замын хөдөлгөөнд саад учруулах, осол аваар, иргэдэд гэмтэл учруулах | 111. Барилгын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын хөдөлгөөн бага үед төлөвлөх. Замын чиглэл өөрчлөх зохих зохицуулалтыг хийж хангалттай тэмдэглэгээ, анхааруулах дохиог ашиглах.<br>112. Хурдны хязгаарыг тогтоож, барилгын тээврийн хэрэгслийн зориулалтын эгнээ буюу зам гаргах.<br>113. Барилгын ажлын тээврийн хэрэгслийн ашиглах зам талбайн байршлыг олон нийтэд мэдээлж, хэрхэн тэдгээртэй зэрэгцэн замын хөдөлгөөнд найдвартай оролцох талаар зааварчилгаа өгөх.<br>114. Барилгын талбайн гадна хэсэгт явган зорчигчид ашиглаж болох гарц, уулзваруудад тэмдэглэгээ хийх..<br>115. Барилгын болон явган хүний замд гэрэлтүүлэг хийх. | Барилгын нийт талбайд | Байнга | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |
| Барилгын талбайн ус зайлуулах дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Ус зайлуулах суваг болон үерийн ус тогтоож барих сангаас ус алдагдах | 116. Ус тогтох, үерлэхээс сэргийлж барилгын талбайгаас хол зайд ус зайлуулах түр байгууламж барих.<br>117. Карьер болон шороон ордыг усаар дүүргэхгүй байх. Тогтсон усыг насосоор тогтмол соруулах.<br>118. Барилгын талбайгаас түр зуурын борооны ус зайлуулах суваг, шуудуут байрлуулах<br>119. Борооны усан хадгалах хадгалах хүчин чадлыг тогтвортой байлгахын тулд гадаргын ус (цөөрөм, гол горхи) хоорондын холболтыг | Голын орчим | Зураг төсөл болон барилгын ажлын үе шатанд | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | | сайжруулж, нэмэгдүүлнэ.<br>Ensure connections among surface waters (ponds, streams) are maintained or enhanced to sustain existing stormwater storage capacity | | | | | | |
| Барилгын ажил ба санамсаргүй олдворын дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Соёлын өв дурсгал, үнэт зүйлсэд хохирол учрах, олдвор олох боломж | 120. Нарийвчилсан зураг төслийн дагуу бүх барилгын ажлыг Жаргалантад болон түүний ойр орчмын соёлын өв, үнэт зүйлсээс хол гүйцэтгэнэ.<br>121. Үнэ цэнэтэй дурсгалт зүйлс, соёлын үнэт зүйлсийг гүйцэтгэгч санамсаргүй олох магадлалтай тул талбайн хянан шалгагч нар хяналт тавих ёстой.<br>122. Санамсаргүй олдвор олсон үед бүх ажлыг нэн даруй зогсоож, олдворт хүрэлгүй байлгаж үнэ цэнэтэй эсэхийг тодруулахаар ТХН-д мэдэгдэнэ. БОАЖЯ-ны соёлын хэлтэст утсаар мэдэгдэнэ.<br>123. БОАЖЯ цааш ажиллахыг зөвшөөрөх хүртэл олдвор олсон талбай дахь ажлыг зогсооно. | Барилгын бүх талбай | Барилгын ажлын эхэнд болон нийт ажлын явцад | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |

***Агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгийн барилгын ажил***

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг барьж байгуулах барилга угсралтын ажил, бүх ажилчид, барилгын материал авах, тээвэрлэх, ашиглах | Богино хугацааны болзошгүй тасалдал, хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх дэд бүтцийн нөлөөлөл | 124. Хот суурины болон агро-үйлдвэрлэлийн дэд бүтцийг барихад зориулж Дээр нарийвчилж тодорхойлсон нөлөөллийг бууруулах арга хэмжээ, дэд төлөвлөгөөнүүд нь агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн барилга угсралтын ажилд хамаарна. | Барилгын бүх талбай | Барилгын ажлын явцын турш | Гүйцэтгэгчийн сар тутмын тайлан | Нэмэлт зардал байхгүй | ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |
| **Агро паркын байршлыг тогтоох: (Хорио цээрийн бүс *(ХЦБ), Лаборатори мал эмнэлгийн үйлчилгээ, Судалгаа шинжилгээний төв, Мах боловсруулах үйлдвэр, үйлдвэрлэлийн төв)*** | | | | | | | | |
| Агро паркын байршлыг тогтоох | Болзошгүй бохирдлын | 125. Лаборатори, судалгааны төв, үйлдвэрлэлийн төвүүдийг орон сууцны байшин, үйлчилгээний газар мөн гадаргын | Жаргаланнтын орчим | нарийвчилсан зураг төслийн эцсийн үе | Final DD report | Нэмэлт зардал байхгүй | ХА/ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| | нөлөөлөл | уснаас хол байрлуулна. Агро паркийн эргэн тойронд мод бут бүхий хашаа барина. | | шатанд | | | | |
| Жаргалантд байх мах боловсруулах үйлдвэрийн газрыг сонгох | Болзошгүй бохирдлын нөлөөлөл | 126. Мал байлгах талбай болон төхөөрөх үйлдвэр, БУЦБ-ийг орон сууц үйлчилгээний барилга мөн гадаргын ус, гүний усны худгаас хол байрлуулж мод эгнүүлж ургуулсан хашаа барина.<br>127. Мах боловсруулах газрын БУЦБ-ийг (цуглуулах усан сан, зайлуулах хоолой) орон сууц үйлчилгээний барилгаас хол байрлуулна.<br>128. Үйлдвэрээс гарах хатуу хог хаягдлыг тухайн талбайд юм уу тусад нь зайлуулах тогтвортой хэрэгжих төлөвлөгөө гаргах. | Жаргалантаас зайтай | нарийвчилсан зураг төслийн эцсийн үе шатанд | Final DD report | Нэмэлт зардал байхгүй | ХА/ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |
| Агро паркын Хорио цээрийн бүс | Гоо зүйн нөлөө үзүүлнэ | 129. ХЦБ-ийг орон сууц, үйлчилгээний барилга, гадаргын уснаас хол байрлуулж, хашаална. | Жаргалантын орчим | нарийвчилсан зураг төслийн эцсийн үе шатанд | Final DD report | Нэмэлт зардал байхгүй | ХА/ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |
| Агро паркын бохир ус цэвэрлэх байгууламжын байршлыг тогтоох | Гоо зүйн нөлөө үзүүлнэ | 130. Агро паркийн дотор БУЦБ-ийг тусад нь төлөвлөж, хашаагаар тусгаарлана. | Жаргалантаас зайтай | нарийвчилсан зураг төслийн эцсийн үе шатанд | Final DD report | Нэмэлт зардал байхгүй | ХА/ХХН/ТХХТЗБ | Гүйцэтгэгч |

***Хот суурины болон агро-үйлдвэрлэлийн дэд бүтцийн ашиглалт***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Шинэ болон өргөтгөсөн дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалт | Тээврийн хэрэгслийн осол аваарийн эрсдэл<br>Агаарын бохирдол | 131. Шинэ болон засаж шинэчилсэн замын дагуу болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдсэн хэсгүүдэд хурдны хязгаар тогтоож, тэмдэгжүүлэх, дагаж мөрдүүлэх<br>132. Зам ашигладаг бүх тээврийн хэрэгсэл нь тогтмол үзлэг хийгддэг, ажиллах нөхцөл зохих журмын дагуу байхыг шаардах | Шинэ болон засаж шинэчилсэн бүх замын дагуу болон шинэ барилга байгууламж руу хүрэх замд | Байнга | Аймаг/сумын Замын газрын хоёр жил тутмын тайлан | Засвар үйлчилгээ | Аймаг, сумын Замын газар |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| Шинэ болон өргөтгөсөн хангамжийн шугам сүлжээ, Жаргалант дахь засаж шинэчилсэн далан, усны сувгийн ашиглалт<br>. | Тоног төхөөрөмжийн эвдрэл, засвар үйлчилгээний хэрэгцээ | 133. Шинэ болон өргөтгөсөн хангамжийн шугам сүлжээ, засаж шинэчилсэн далang тогтмол шалгаж засвар үйлчилгээ хийж байх | Жаргалант | Байнга | Хоёр жил тутам<br>Ховд аймаг /Жаргалантын НААҮГ / ЗДТГ-ын тайлан | Засвар үйлчилгээ | Ховд аймгийн ЗДТГ, НААҮГ | |
| Жаргалант дахь одоо байгаа болон шинэ, шинэчилж өргөтгөсөн БУЦБ-ын болон цэвэрлэсэн усны чанарыг ашиглалтыг тогтмол хянах | Буянт голын бохирдол | 134. БУЦБ хот суурин газраас ирэх бохир усны нэмэгдсэн ачааллыг хэр зэрэг цэвэрлэж байгаа болон цэвэрлэсэн бохир усны чанар нь ОУСК-БОЭМААУ стандартад нийцэж байгаа эсэхийг хянаж шинжилж байх шаардлагатай. | Жаргалантын БУЦБ, түүнээс хаягдах цэвэрлэсэн ус | Улирал тутам | | | | |
| Жаргалантад ажиллаж буй дулааны станцын ашиглалтыг тогтмол хянах | Агаарын бохирдол | 135 Дулааны станцын хүчин чадал нэмэгдсэнээс үүдэн станцаас гарах утаа үндэсний болон ОУСК-БОЭМААУ (2007) стандартын түвшнээс хэр зэрэг зөрж байгааг тодорхойлохын тулд одоо ажиллаж байгаа дулааны станцыг хянаж шалгаж байх шаардлагатай. | Жаргалантын ДС | Улирал тутам | Хоёр жил тутам<br>Ховд аймаг /Жаргалантын НААҮГ / ЗДТГ-ын тайлан | Засвар үйлчилгээ | Ховд аймгийн ЗДТГ, НААҮГ | |
| ***Агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн ашиглалт*** | | | | | | | | |
| **Мах боловсруулах үйлдвэр** | | | | | | | | |
| Мах боловсруулах үйлдвэрт хэрэглэх гүний усны хангамжийг хянах | Төхөөрөх үйлдвэрт болон бусад гүний ус хэрэглэгчдэд ус хүрэлцэхгүй болох | 136. тухайн талбайн гүний усны түвшин, гүний усны хүрэлцээ, төхөөрөх үйлдвэр болон бусад хэрэглэгчдэд учирч болзошгүй хомсдолыг хянах шаардлагатай. | Мөл төхөөрөх үйлдвэрийн орчин | Сар бүр | Хоёр жил тутам<br>Жаргалантын ЗДТГ-ын тайлан | Засвар үйлчилгээ | Ховд аймгийн ЗДТГ | |
| Мах боловсруулах | Цэвэрлэсэн хаягдал | 137. Цэвэрлэсэн хаягдал усны чанар, тухайн | Мөл төхөөрөх | Хоёр жил тутамд | | | | |

| АСТБХХОХ-ийн үйл ажиллагаа | Болзошгүй байгаль орчны нөлөөллүүд | Санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Байршил | Хугацаа | Үйл ажиллагааг тайлагнах | Төсөвт өртөг (ам.доллар) | Хариуцах эзэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт | Гүйцэтгэл |
| үйлдвэрээс гарах цэвэрлэсэн хаягдал ус, хатуу хог хаягдлыг хянаж шинжлэх | усыг нийлүүлэх Буянт голын болон орчмын газрын бохирдол | цэгээс доошхи Буянт голын усны чанар, хатуу хог хаягдлыг зайлуулах цэгийн байршлыг үндэсний болон ОУСК-БОЭМААУ стандартад нийцэж буй эсэхийг хянах шаардлагатай. | үйлдвэрт, ус нийлүүлж буй байршил, хог хяах цэгт | | | | | |

# VI. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

30. 102. Ховд аймгийн БОМТ-ний орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг хүснэгт 5-д үзүүлэв. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг 1-р ээлжинд гүйцэтгэх ажлын гурван үе шатны (барилга угсралтын ажлын өмнөх үе, барилгын ажил, барилга угсралтын дараах ашиглалт) дагуу боловсруулсан бөгөөд байгаль орчны үзүүлэлт, хяналтын дээж авах байршил, давтамж, мэдээлэл цуглуулах арга, хариуцагч талууд, зардлын тооцооноос бүрдэнэ. Орчны хяналт-шинжилгээний төлөвлөгөөний зорилго нь нөлөөллийг бууруулах ажлын үр дүнг тодорхойлох, мөн төслийн бүрэлдэхүүн хэсгүүдээс хүрээлэн буй орчинд үзүүлж буй эерэг олон сөрөг нөлөөллийг баримтжуулах явдал юм. 1-р ээлжийн төслийн талбайн байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд зориулж дээж авсан цэгүүд дээр орчны хяналт шинжилгээ хийгдэнэ.

## A. АСТБХХОХ-ийн 1-р ээлжид хамааралтай байгаль орчны чанарын стандартууд

31. Монгол улсын Байгаль орчны чанарын стандарт болон шалгуур үзүүлэлтийг Хавсралт А-д үзүүллээ. Хэрэв шаардлагатай бол эдгээр стандартад нэмэлт болгож ОУСК/ДБ-ны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамжид (2007) заасан хүрээлэн буй орчны стандартыг ашиглах хэрэгтэй. Хамгийн өндөр шаардлага бүхий стандартыг нь дагаж мөрдөнө.

32. БОНҮ гүйцэтгэх эрх бүхий ААН нь ХХН/ТХХТЗБ-ийн хяналт, зохицуулалтын дагуу орчны хяналт-шинжилгээг гүйцэтгэнэ. БОНҮ гүйцэтгэх эрх бүхий ААН нь орчны параметрүүдийн дээж авах, лабораторийн шинжилгээ хийх ажлыг хариуцна. ХХН болон ТХХТЗБ-БООУМ нь хяналт-шинжилгээний ажлыг энэхүү ААН-тэй уялдуулан зохицуулна. ХХН ба ТХХТЗБ нь шаардлагатай тохиолдолд орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нь БОНҮ гүйцэтгэх эрх бүхий ААН-д логистикийн дэмжлэг үзүүлнэ

## B. Гүйцэтгэлийн хяналт

33. БОМТ-ийн нийт үр дүнг үнэлэхийн тулд гүйцэтгэлийн хяналт шаардлагатай болно. Нийт төслийн хувьд гүйцэтгэлийн хяналтын системийг ГА (БХБЯ) боловсруулдаг. Нөлөөллийг бууруулах болон хяналт шинжилгээний төлөвлөгөөнөөс 1-р ээлжийн барилга угсралтын болон ашиглалтын үе шатны явцад нөлөөлөх байгаль орчны үзүүлэлтүүдийг сонгон авч хүснэгт 6-д нэгтгэж үзүүлэв.

## C. Тайлагнах

34. 1-р ээлжийн барилга угсралтын ажлын явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээний болон хяналт-шинжилгээний хэрэгжилтийн талаар тогтмол тайлагнах шаардлагатай. Тайлан гаргах үүргийг ХХН/ТХХТЗБ хүлээх ба үүнийг холбогдох талуудын харилцааны тасралтгүй үйл ажиллагааны хүрээнд тэдний оролцоотой тогтмол уулзалтуудтай хамтруулан хийх ёстой. Нөлөөллийг бууруулах ба хяналт шинжилгээний төлөвлөгөөнд (4-5-р хүснэгтүүд) санал болгож буй тайлан гаргах хугацааг нэгтгэн харуулав. Хавсралт В-д жишиг хяналт шинжилгээний тайланг үзүүлэв.

35. ХХН нь Ховд аймгийн Жаргалантын БОМТ-ний байгаль орчны хяналт, хэрэгжилтийн талаархи жилийн тайланг дараагийн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэнэ. ХХН-ийн тайланд гүйцэтгэгчдийн сар тутмын тайлан, БОНҮ хийх эрх бүхий ААН-ийн хийсэн орчны хяналт шинжилгээний тайлан, ТХХТЗБ-ын байгаль орчны олон улсын мэргэжилтний тайланг нэгтгэсэн байна. ХХН-ийн тайланг орон нутгийн байгаль орчны газар, БОАЖЯ, АХБ руу явуулна. Уг тайланд гүйцэтгэлийн хяналтын шалгуур үзүүлэлтүүдийг оролцуулан БОМТ-ний хяналт шинжилгээний төлөвлөгөөний дагуу хэмжсэн бүх үзүүлэлтүүдийг хүснэгтэлж нэгтгэх бөгөөд БОАЖЯ-ны байгаль орчны чанарын холбогдох стандартыг лавлагаа болгож оруулсан байна.

## Table 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ – ХОВД АЙМАГ

| ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Орчны үзүүлэлтүүд** | **Байршил** | **Хяналт-шинжилгээ хийх арга хэрэгсэл** | **Давтамж** | **Тайлагнах** | **Хариуцах эзэн** | | **Төсөвт өртөг (ам.доллар)** |
| | | | | | **Хяналт** | **Гүйцэтгэл** | |
| ***Барилга угсралтын ажлын өмнөх үе шат – Байгаль орчны суурь үзүүлэлтийг бүрдүүлэх*** | | | | | | | |
| Хуурай улирлын хамгийн бага урсацтай үеийн гүний усны түвшин (м) ба гүний усны хангамж (м$^3$/сек) | (i) шинэчилсэн БУЦБ, шинэ худаг (ii) мах боловсруулах шинэ үйлдвэр (iii) Жаргалант дахь шинэ агро паркаас дээш хэсэгт | Одоо байгаа гидро-геологийн тайлан үндэсний стандарт, олон улсын гидро-геологийн аргаууд | Хуурай боолн бороотой улиралд хоёр удаа | Нэг удаа | ХХН/ТХХТЗБ | БОНҮ хийх эрх бүхий ААН | $1,000. |
| Гүний усны чанар (үндсэн ион, pH, эрдэсжилт N & P, Pb, Hg, Fe, Zn) | Шинэ худаг болон хог хаягдлын 2 цэгт | MNS (ISO) 5667-11:2000 | Хуурай улиралд нэг удаа | | | | $2,000. |
| Сар тутмын хамгийн бага урсац (м$^3$/сек) | Буянт гол дээр Жаргалантын услалтын систем салаалах цэгт | Одоо байгаа тайлан & MNS OIML R 102:2001<br>MNS 4047:1988 | Хуурай болон бороотой улиралд нэг удаа (хамгийн их ба бага) | | | | $1,000. |
| ДЦС-ын утааны найрлага (CO, NOx, SOx, $CO_2$) | Жаргалантад ажиллаж буй ДЦС | MNS 0017-2-3-16, 1998<br>MNS OIML R 102:2001<br>MNS 4047:1988.<br>MNS (ISO) 5667-11:2000 | Станцын бүрэн ашиглалтын үеэр нэг удаа | | | | $1,250. |
| Нийтийн хэрэгцээний ундны ус түгээх цэг болон соёлын өв, үнэт зүйлсийн байршлуудыг баталгаажуулах | Жаргалант дахь төслийн хоёр талбайд нийтэд нь | Оршин суугчидтай зөвлөлдөх | Нэг удаа | | | ТХХТЗБ-БООУМ | Нэмэлт зардал байхгүй |
| Хөрсөнд бохирдол үүсгэж болзошгүй одоогийн ба хуучин газар ашиглалтын бүртгэл хийх. | Төслийн бүх ухлага, малтлага хийгдэж буй талбайд бохирдсон байж болзошгүй газар | Одоо байгаа тайлан, БОАЖЯ-р батлагдсан хээрийн ба аналитик аргыг ашиглах | Нэг удаа | Нэг удаа | ХХН/ТХХТЗБ | БОНБҮ хийх эрх бүхий ААН | $200. |
| Олон нийттэй холбогдсон асуудлууд/ санал хүсэлт | Төслийн бүх талбайд | Шууд утас, СГБМ-ыг ажиллуулж эхлэх | Байнга үргэлжлэх | Сар бүр | ХХН/ТХХТЗБ | ТХН | Нэмэлт зардал байхгүй |
| ***Хот суурины болон агро-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн барилга угсралтын үе шат*** | | | | | | | |
| Олон нийтийн санал, | Төслийн бүх хэсэг, мөн | Information transferred | Олон нийтийн зүгээс байнга | | ХХН/ТХХТЗБ | ТХН | Нэмэлт |

| ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
